Нийслэлийн Хяналт шалгалтын газрын
2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн
01/1206 дугаар албан бичгийн
1 дүгээр хавсралт

# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧТАЙ БАЙГУУЛСАН 2025 ОНЫ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 11 дүгээр сарын 28 — Улаанбаатар хот

| Д/д | Гэрээний заалтын утга | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | 2.1.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах; | Нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээг газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж, дараах хугацаанд тайлагнаж ажиллав. Үүнд:<br>➢ Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 2 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.<br>➢ “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан нийт 8 арга хэмжээний хэрэгжилтийг нотлох баримтын хамт нэгтгэн, 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/768 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэв.<br>➢ “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2025 оны хэрэгжилтийг 2025 оны 12 дугар сарын 01-ний өдрийн 01/1192 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>➢ “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/1193 | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. | |
| 2 | 2.1.2.Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах; | Монгол Улсын Засгийн газрын гишүүд болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан хамтран ажиллах дараах 6 сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд байгууллагын эрхлэх асуудал, чиг үүрэгтэй уялдуулан нийт 19 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/17 дугаар тушаалаар баталсан. Үүнд:<br>1) Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга- 2 арга хэмжээ;<br>2) Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хороо- 2 арга хэмжээ;<br>3) Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд- 1 арга хэмжээ;<br>4) Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд- 6 арга хэмжээ;<br>5) Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд- 3 арга хэмжээ;<br>6) Эрчим хүчний сайд- 5 арга хэмжээ.<br>Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар тайлагнаж ажиллав. Үүнд:<br>➢ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай байгуулсан гэрээний эхний хагас жилийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр НЗДТГ-т цахимаар хүргүүлсэн.<br>➢ Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргатай байгуулсан гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/535 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.<br>➢ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1163 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>➢ Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | өдрийн 01/1164 дугаартай НЗДТГ-ын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. | |
| 3 | 2.1.3.Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах; | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/596 дугаар захирамжаар тус газар нь 6 нэгж, 98 хүртэлх орон тоог баталснаас нийт 67 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Байгууллагын хэмжээнд удирдах албан тушаалтан 6, гүйцэтгэх албан тушаалтан 35, төрийн үйлчилгээний 26 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд барилга, дэд бүтцийн салбарын зөвлөх болон мэргэшсэн инженер зэрэглэлтэй 16 албан хаагч байна. Төрийн албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах зорилгоор дараах үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Үүнд:<br>- Хүний нөөцийн үйл ажиллагааны хүрээнд нийт 124 тушаал батлагдсан бөгөөд үүнээс ажилд томилсон 65, ажлаас чөлөөлсөн 26, сахилгын шийтгэл ногдуулсан 8, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосон 4, нэмэгдэл олгосон 10, бусад чиглэлээр 8 тушаал тус тус гарсан байна.<br>- Сул орон тоог нөхөн бүрдүүлэх, ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор UB ERP системд нийт 3 удаа зар тавьж, материалаа ирүүлсэн 28 нэр дэвшигчтэй ярилцлага зохион байгуулан, Төрийн албаны тухай хууль болон “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын дагуу 15 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан.<br>- Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын улсын (ахлах) байцаагч нарын эрх олгуулах, цуцлуулах, тамга, үнэмлэх шинээр хийлгэх саналыг харьяа яамдад хүргүүлж, салбарын сайдын эрх олгосон тушаалыг үндэслэн 7 байцаагчийн эрхийг олгосон. Мөн улсын байцаагчийн эрх цуцлуулах 3 хүсэлтийг Зам, тээврийн яам болон Эрчим хүчний яамaнд хүргүүлж, цуцлуулсан.<br>- Төрийн албан хаагчдын үүрэг хариуцлагыг тодорхой болгож, хариуцлага алдагдсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах тогтолцоог боловсронгуй болгож байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг газрын даргын 2025 оны А/20 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Уг журмын дагуу 34 удаагийн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | санууллах арга хэмжээ, 8 удаагийн сахилгын шийтгэл ногдуулсан байна. | |
| 4 | 2.1.4.байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах; | Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл “Төсвийн цаглавар”-ын дагуу сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ, улирал бүр санхүүгийн болон татварын тайланг хугацаанд нь үнэн зөв гарган, холбогдох байгууллагуудаар баталгаажуулан ажиллав. 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар байгууллагын батлагдсан төсвийн гүйцэтгэл 74,25 хувийн хэрэгжилттэй байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/87 дугаар албан бичгээр хүргүүлсэн "2025 оны төсвийг нэмэгдүүлж тодотгол хийлгүүлэх тухай" хүсэлтийн дагуу, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/552 дугаар захирамжаар тус байгууллагын төсвийг 218.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, холбогдох ажлыг хэрэгжүүлэн ажиллав.<br>Төсвийн гүйцэтгэлийн 2025 оны 11 дүгээр сарын мэдээгээр байгууллагын батлагдсан төсөв 3,371,472.7 мянган төгрөг, гүйцэтгэл 2,894,740.5 мянган төгрөг буюу 85.9 хувьтай байна. Нэмэлт санхүүжилтээр НГХУССЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 346,786.5 мянган төгрөгийг зарцуулсан. Төсвийн тухай хуулийн “8 дугаар зүйл.Төсвийн цаглавар”-ийн дагуу төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ (10 удаа), санхүүгийн тайланг (3 удаа) хуулийн хугацаанд үнэн зөв гарган Нийслэлийн санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж тайлагнан ажилласан. | 100% |
| 5 | 2.1.5.хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах; | Хариуцсан чиг үүргийн хүрээнд байгууллагыг шүүхэд төлөөлөх үүргийг хэрэгжүүлж, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг төлөөлж нийт 16 хэрэг, маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хууль тогтоомжийн дагуу оролцсон. Үүнээс бүрэн шийдвэрлэгдсэн маргаан 9, хянан шийдвэрлэгдэх шатанд байгаа маргаан 7 байна. | 100% |
| 6 | 2.1.6.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах; | Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөн ажиллах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулж байна.Үүнд:<br>- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 захирамжийн дагуу Ерөнхий менежерийн А/31 тушаалаар батлагдсан ажлын хэсэг | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй байршуулсан барилгын өргөтгөл, шаардлага хангахгүй барилгын түр хашаа, түц, хашаа, хайс, зөөврийн байгууламж, зар сурталчилгааны байгууламжуудад Улсын байцаагчийн албан даалгавар 22, албан шаардлага 77, зөвлөмж 91, Торгууль 12, мэдэгдэх хуудас 1, шаардах хуудас 113 хүргүүлж ажиллаад байна. Мөн хяналт шалгалтын ажлын хүрээнд нийт 470 байршилд ажиллаж 290 зөрчил бүртгэлжүүлэн 99 зөрчлийг арилгуулж ажилласан тайлан мэдээг нэгтгэн холбогдох байгууллагад хугацаанд нь тайлагнан ажиллав.<br>- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 53 дугаар тогтоолыг хавсралтаар батлагдсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний дагуу хаягдал усны бохирдлыг бууруулахад нөлөөлж буй арьс шир боловсруулах, ноос ноолуур угаах, боловсруулах, өлөн боловсруулах, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, талх чихэр, архи ундааны үйлдвэрээс урьдчилсан цэвэрлэх байгууламж суурилуулаагүй, хаягдал бохир усны чанар, урьдчилсан цэвэрлэх байгууламжтай эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн нийт 49 үйлдвэр хамрагдлаа. | |
| 7 | 2.1.7.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах; | Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийн төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэв. Хөтөлбөрийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхээр болов.<br>Барилгын ажил гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, барилгын талбай болон түүний гаднах эрсдэлтэй бүсийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | зорилгоор “Нийслэл дэх барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагуудаас санал авч нэгтгэн, нөлөөллийн шинжилгээний хамт 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 01/242 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | |
| 8 | 2.1.8.дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах; | Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, болон хэлтсүүдийн дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд 2025 онд 8 удаа дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдох дүгнэлт, зөвлөмж хүргүүлэв. Үүнд:<br>➢ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд түүвэрчилсэн байдлаар хяналт шалгалт хийж, нийт 108 баримт бичигт хяналт шалгалт хийж, 11 зөрчил илрүүлж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br>➢ Авлигатай тэмцэх газар, Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийн дагуу дотоод хяналт шалгалт зохион байгуулж, 2 албан хаагчид холбогдох зөрчлийн хүрээнд захиргааны арга хэмжээ авч, 1 албан хаагчид сануулах арга хэмжээг авч, 1 асуудалд холбогдуулан хариу тайлбар хүргүүлсэн.<br>➢ Газрын даргын 2025 оны “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/53 дугаар тушаалын дагуу барилгын ажлын зөвшөөрөлгүй болон баримт бичгийн бүрдэл хангагдаагүй барилгуудыг ашиглалтад оруулж буй эсэхэд дотоод хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт гарган үр дүнг газрын даргад танилцуулж, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэст зөвлөмж, цаашид авах арга хэмжээний санал хүргүүлэв.<br>➢ Газрын даргын баталсан удирдамжийн дагуу 6 хэлтсийн албан хаагчдыг хамруулан, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт хууль, дотоод журмын дагуу хийгдэж байгаа эсэхэд 5 чиглэл, 12 шалгуур үзүүлэлтээр хяналт хийж, илэрсэн зөрчил, сайжруулах шаардлагатай асуудалд зөвлөмж хүргүүлсэн<br>➢ “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай” газрын даргын баталсан удирдамжийн дагуу Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн үйл ажиллагаа, төрийн хяналт шалгалт, хууль эрх зүйн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | хэрэгжилтийн байдалд 9 чиглэл, 33 шалгуур үзүүлэлтээр, мөн Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн үйл ажиллагаа, төрийн хяналт шалгалт, хууль эрх зүйн хэрэгжилтийн байдалд 5 чиглэл, 10 шалгуур үзүүлэлтээр тус тус дотоод хяналт шалгалт зохион байгуулж, санал, зөвлөмж хүргүүлсэн. | |
| 9 | 2.1.9.төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх; | Нийслэлийн Хяналт шалгалтын газрын албан хаагчдын амьдралын нөхцөл, ажиллах орчин, нийгмийн баталгаа, тулгамдсан асуудал, ирээдүйн хэрэгцээг тодорхойлоход чиглэгдсэн судалгааг нийт 61 албан хаагчийг хамруулан 6 бүлэгт хуваан нийт 31 асуултаар явуулсан. Судалгааны үр дүнд үндэслэн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулав. “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:<br>➢ Удирдлагын академийн 2025 оны сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу Төрийн албаны тухай холбогдох хууль тогтоомжид заасан дараах, төрлийн сургалтад 5 албан хаагч хамрагдсан. Үүнд: Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт-2, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт-1, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалт-2 албан хаагч тус тус хамрагдсан.<br>➢ Салбарын чиглэлээр 5 албан хаагч магистрын сургалтад хамрагдсан.<br>➢ Мэргэшсэн архитектор, инженер, төсөвчин зэргийг сунгах, зөвлөх архитектор, инженер, тэргүүлэх төсөвчин зэргийг горилох, сунгах сургалтад тус газрын 5 албан хаагч хамрагдсан.<br>➢ Албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх хүрээнд гадаадын 5 удаагийн сургалт, зөвлөгөөний хөтөлбөрт нийт 28 албан хаагчийг хамруулан мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэн ажиллав.<br>➢ Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр гадаадын сургалт, зөвлөгөөний хөтөлбөрт 5 удаа, нийт 28 албан хаагч хамрагдсан.<br>➢ Байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад хамруулах | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | ➢ Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/578 дугаар захирамжийг үндэслэн газрын даргын тушаалаар 10 албан хаагчид төрийн захиргааны албан хаагчдад олгох зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгов.<br>➢ 3 албан хаагчид мэргэшсэн инженерийн нэмэгдлийг олгуулав.<br>➢ Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 02 дугаар сарын 12-14-ний өдөр нийт 50 албан хаагчийг “Эрт илрүүлэг” шинжилгээнд хамруулав. Мөн Монос ХХК-тай хамтран “Эрүүл мэндийн өдөрлөг” нээлттэй арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, эрдсийн шинжилгээ, арьс оношилгоо, ясны сийрэгжилт, шүдний эмчийн үзлэг гэсэн 4 төрлийн эрүүл мэндийн үзүүлэлтээр оношилгоог хийсэн.<br>➢ НЗДТГ-ын даргын А/185 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалын орон сууцанд хамрагдсан оршин суугчдын дагаж мөрдөх журам”-ыг танилцуулж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/531 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Уг хөтөлбөрт хамрагдсан 4 албан хаагчийн 2 нь эхний ээлжийн орон сууцанд хамрагдаж, үлдсэн 2 албан хаагч нь дараагийн ээлжид хамрагдахаар хүлээгдэж байна. | |
| 10 | 2.1.10.алба хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авах; | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хорооны даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн шийдвэрээр 2 зорилтын 8 арга хэмжээг төлөвлөж, тайлант хугацаанд хэрэгжилтийг ханган ажиллав. Үүнд:<br>➢ Төрийн албан хаагчдын ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хорооноос албан хаагчдын харилцаа, зан төлөв, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулсан бөгөөд сургалтуудыг “Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” болон “Стресс ба ажлын байран дахь харилцаа” гэсэн сэдвээр явуулсан.<br>➢ Иргэн болон хуулийн этгээдээс ирүүлсэн 3 гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэн дүгнэлтийг албажуулж, газрын даргад танилцуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | ➢ "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх аян"-ы хүрээнд албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, урам зориг өгөх зорилгоор "Талархлын самбар"-ыг байршуулж, хэлтсүүдэд дарцаг шилжин явах арга хэмжээг хэрэгжүүлэн үлгэр жишээ хэлтсийг шалгаруулах ажлыг зохион байгуулж байна.<br>➢ Байгууллагын албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 2025 оны сургалтын төлөвлөгөөг 7 бүлгийн хүрээнд нийт 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр нэгтгэн удирдлагад танилцуулсан бөгөөд нийт 38 арга хэмжээ 99.47 хувьтай хэрэгжсэн байна. | |
| 11 | 2.1.11.төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх; | 1. Нийслэлийн хэмжээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулах хүсэлтийг төрийн үйлчилгээний нэгдсэн портал болох www.e-mongolia.mn, www.e-business.mn, www.edoc.ulaanbaatar.mn зэрэг цахим системүүдээр дамжуулан шаардлагатай баримт бичгийн бүрдлийн хамт хүлээн авч, иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн хүсэлтүүдийг ажлын 5-7 хоногийн хугацаанд судлан шийдвэрлэж байна. 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 1848 хүсэлт хүлээн авч, судлан шийдвэрлэсэн бөгөөд систем тус бүрээр дараах байдлаар ангилав. Үүнд:<br>www.e-mongolia.mn - цахим системээр:<br>• Барилга байгууламж – 439<br>• Цахилгаан хангамж – 758<br>• Засвар, тохижилт – 16<br>www.e-business.mn - цахим системээр:<br>• Барилга байгууламж – 116<br>• Цахилгаан хангамж – 110<br>www.edoc.ulaanbaatar.mn Нийслэлийн дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр:<br>• Барилга байгууламж – 140<br>• Цахилгаан хангамж – 70<br>• Засвар, тохижилт – 199 | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | 2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 2918 өргөдөл, гомдол хүлээн авснаас 100 буюу 3.43 хувь нь судлагдаж байгаа, 2818 буюу 96,57 хувь нь хугацаанд нь шийдвэрлэгдсэн байна. Өргөдөл, гомдлыг ангилбал:<br>➢ Талархал – 10 (0.12%)<br>➢ Санал – 12 (0.14%)<br>➢ Хүсэлт – 975 (11.45%)<br>➢ Гомдол – 1892 (22.22%)<br>➢ Мэдэгдэл – 10 (0.12%)<br>➢ Зөрчил – 5 (0.38%)<br>3. Байгууллагын үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгжүүдийн сэтгэл ханамжийг үнэлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг байгууллагын цахим хуудсаар дамжуулан тогтмол авч байна. Судалгаагаар ирсэн санал, шүүмжлэл, давтамж өндөртэй асуудлуудыг үндэслэн үйлчилгээний хурд, ил тод байдал, цахим хүртээмжийг сайжруулж, дотоод зохион байгуулалт болон албан хаагчдын харилцаа, хандлагыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. | |
| 12 | 2.1.12.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх; | 1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх тухай” А/61 дүгээр захирамжийн хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хяналт шалгалт хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, болон байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үйл ажиллагааны талаар тус тус танилцуулав.<br>2. Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2024 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж, санхүүгийн байдал болон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу “Зөрчилгүй” дүгнэлт хүлээн авч ажиллав. Хяналт шалгалтын газрын 2024 оны | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн НТАГ-2025/229/НА-СТА-ТШЗ кодтой аудитын тайлангаар ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/960 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. | |
| 13 | 2.1.13.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 дүгээр захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах; | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1024 дүгээр захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс хариуцсан чиг үүргийн дагуу индексийн үзүүлэлтийг үйл ажиллагаандаа уялдуулж, сайжруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх талаар байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгав. | 90% |
| 14 | 2.1.14.хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох; | Хотын хөгжлийн индексийн 86 үзүүлэлтээс байгууллагын чиг үүрэгтэй уялдах 6 үзүүлэлтийг тодорхойлон, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгасан. | 70% |
| 15 | 2.1.15.чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах; | Нийслэлийн иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулах, хотын стандарт, нормыг мөрдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:<br>- Нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй байршуулсан өргөтгөл, стандартын шаардлага хангаагүй түр хашаа, түц, зар сурталчилгааны байгууламж болон бусад зөрчилтэй объектод нийт 22 албан даалгавар, 77 албан шаардлага, 91 зөвлөмж, 12 торгууль, 1 мэдэгдэх хуудас, 113 шаардах хуудас хүргүүлж, 470 байршилд хяналт шалгалт хийснээс 290 зөрчлийг илрүүлж, 99-ийг арилгуулсан.<br>- Барилгын түр хашааны стандарт хангаагүй, аюулгүй байдал алдагдсан 28 байршилд зөрчлийг арилгуулж, стандартыг мөрдүүлсэн.<br>- Нийтийн эзэмшлийн явган хүний замын төлөв байдлыг шалгаж, 7 албан шаардлага хүргүүлж, орц гарц гаргасан 2 байгууллагад 10 сая төгрөгийн торгууль ногдуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| 17 | | - Сонгинохайрхан болон Баянзүрх дүүрэгт нийт 49 байршилд хоёрдогч түүхий эд авах цэгүүд болон тос тосолгооны материал худалдаалах, авто засвар, авто угаалга, дугуй засварын үйл ажиллагаа эрхэлдэг 45 байршилд шаардах хуудас хүргүүлж, үлдсэн 4 байршилд тухайн дүүргүүдийн Газар зохион байгуулалтын албанаас мэдэгдэх хуудас хүргүүлэв.<br>- Ахуйн хог тээвэр, нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ эрхлэгч 20 байгууллагын 298 тээврийн хэрэгсэл, 17 зогсоол, 17 засварын байрт хяналт шалгалт хийж, 214 зөрчил илрүүлэн 20 албан шаардлага хүргүүлсэн.<br>- Эмнэлгийн гадна орчны аюулгүй байдлыг шалгаж, 20 байгууллагад хяналт хийж, 14-д хугацаатай үүрэг өгч зөрчлийг 90 хувьтай арилгасан.<br>- Хүн амын нягтаршил ихтэй бүсэд байрлах 50 ШТС, 3 АХЦС-ыг хамруулсан шалгалт хийж, 53 албан шаардлага, 10 заалт бүхий 7 албан даалгавар хүргүүлж биелэлтэд хяналт тавьж ажиллав.<br>- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан 18 байгууллагуудад ашиглалт үйлчилгээг сайжруулах талаар мэдэгдэл хүргүүлсэн.<br>- 2024, 2025 он дамжин хэрэгжиж буй авто зам, замын байгууламжийг сэтэлж, сүвлэх зөвшөөрөл олгосон 73 байршлын нөхөн сэргээлтийг хийх тухай албан шаардлагыг Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д хүргүүлэв.<br>- “Дуу чимээний бохирдол” хотын стандартыг хэрэгжүүлэх ажлын шөнийн цагаар барилга угсралтын ажил гүйцэтгэхтэй холбоотой зөвлөмжийг 168 байгууллагад хүргүүлж, дуу чимээ гаргасан талаарх гомдлын тоо буурсан үзүүлэлттэй байна. | |
| 16 | 2.1.16.чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний судалгааны нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх; | Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг төслийг шинэчлэн боловсруулж, иргэд, олон нийтээс санал зорилгоор https://www.inspection.ub.gov.mn байгууллагын цахим хуудсанд байршуулсан. | 100% |
| 17 | 2.1.17.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, | Байгууллагын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 2918 өргөдөл, гомдол хүлээн авснаас 100 буюу 3.43 хувь нь | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах; | судлагдаж байгаа, 2818 буюу 96,57 хувь нь хугацаанд нь шийдвэрлэгдсэн байна. Өргөдөл, гомдлыг ангилбал:<br>➢ Талархал – 10 (0.12%)<br>➢ Санал – 12 (0.14%)<br>➢ Хүсэлт – 975 (11.45%)<br>➢ Гомдол – 1892 (22.22%)<br>➢ Мэдэгдэл – 10 (0.12%)<br>➢ Зөрчил – 5 (0.38%)<br>Байгууллагын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, гарч буй зөрчлийн талаар газрын дарга, нэгжийн удирдлагуудад тогтмол танилцуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад нийт 183 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс:<br>➢ Хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн – 10<br>➢ Явцын тэмдэглэл хөтлөөгүй – 68<br>➢ Өдөрт нь багтаан шилжүүлээгүй – 48 Өдөрт нь багтаан хүлээн аваагүй – 60<br>➢ Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй – 7<br>Байгууллагын хэмжээнд нийт албан хаагчдыг хамруулан, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд 5 чиглэл, 12 шалгуур үзүүлэлтээр дотоод хяналт шалгалт хяналт хийж, илэрсэн зөрчил, сайжруулах шаардлагатай асуудалд зөвлөмж хүргүүлсэн. Шийдвэрлэлтийн явцад удаа дараа зөрчил гаргасан нийт 18 албан хаагчид байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу “Хяналтын шар хуудас” олгож, сануулах арга хэмжээ авч, хариуцлага тооцсон. Мөн 2 албан хаагчид сахилгын арга хэмжээг авсан. | |
| 18 | 2.1.18.Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Нийслэлийн Засаг даргын баталсан захирамж, албан даалгавар, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, чиг үүргийн хүрээний судалгаа, тайлан мэдээг тухай бүр заасан хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж байна. Байгууллагын хэмжээнд нийт 206 албан бичиг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн байна. Тухайлбал, хариу хүргүүлэх тухай 31, мэдээлэл хүргүүлэх тухай 8, Хяналт шалгалтын мэдээлэл, дүнгийн танилцуулга хүргүүлэх тухай 8, тайлан, биелэлт хүргүүлэх тухай 19 бичиг байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 22 удаа зохион байгуулагдаж, газрын чиг үүрэгт хамаарах нийт 81 үүрэг даалгавар (үндсэн хэрэгжүүлэх 28) өгөгдөн, 93,1 хувьтай хэрэгжсэн. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр дүүрэг, хороодын Засаг дарга нартай хийсэн ээлжит 03 дахь уулзалтаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 01/1037 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан. | |
| 19 | 2.1.19.энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах; | Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нийт 4 бүлэг, 35 зорилт 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 95 хувьтай, жилийн эцсийн байдлаар 97.6 хувьтай тус тус хэрэгжсэн байна. | 100% |
| 20 | 2.1.20.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх; | 2025 оны байдлаар Хяналт шалгалтын газрын даргын А тушаал 100, Б тушаал 124 тус тус батлагдсан бөгөөд эдгээр тушаалыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулж, мөн байгууллагын өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж байна. | 90% |
| 21 | 2.1.21.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах; | - Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган, байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн мэдээллийг https://shilendans.gov.mn/ цахим системд тухай бүр байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж олон нийтэд мэдээлж, төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна. 2025 оны 10 дугаар сарын байдлаар шилэн дансанд байршуулах 135 мэдээллийг бүрэн (100%) байршуулсан бөгөөд үүнээс 130 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.<br>- “Хяналт шалгалтын газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр газрын даргаар батлуулав. Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/38 дугаарын тушаалаар “Үнэлгээний хороо”-г байгуулж, 7 төрлийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагааг зохион | 90% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | байгуулж, шалгарсан байгууллага, ААН-тэй гэрээ байгуулан худалдан авалтыг хийж, тайлагнан ажилласан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд харьцуулалтын аргыг хэрэглэн байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, шууд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | |
| 22 | 2.1.22.гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулах; | Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх, зохион байгуулах үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, хамтран ажиллаж байна. Гадаад харилцааг өргөжүүлэх, хөгжүүлэх зорилгоор нийт 14 албан бичиг, 1 хөтөлбөр, 3 тушаал, 9 ажил байдлын тодорхойлолт боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | 100% |
| 23 | 2.1.23.хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх; | Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллийг нээлттэй, ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хамтран ажиллах төлөвлөгөө”-г 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр газрын даргаар батлуулж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 32 мэдээ, нийтлэлийг www.ulaanbaatar.mn цахим хуудсанд нийтэлсэн байна. | 100% |
| 24 | 2.1.24.Нийслэлийн Засаг даргын "2025 оныг Бүтээн байгуулалтын жил болгон зарлах тухай" 01 дүгээр захирамжийн дагуу бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх; | Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг “Улаанбаатар хотын дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан мөн Нийслэлийн Засаг даргаас 2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан барилгын салбарт ажиллагсад, удирдлага, инженер техник, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны ажилтан албан хаагчдад хууль эрх зүйн мэдээлэл өгөх, салбарт тулгамдаж буй асуудал болон ослоос урьдчилан сэргийлэх, техникийн аюулгүй ажиллагааг хангуулах, туршлага судлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор "Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нарыг чадавхжуулах" сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллагууд, угсралт | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | ажил гүйцэтгэгч 180 гаруй аж, ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөл хамрагдсан. | |
| 25 | 2.1.25.барилга байгууламж, орчны аюулгүй байдал, инженерийн шугам сүлжээ, зам, замын байгууламжийн чанар, ашиглалт, засварын ажлын гүйцэтгэл, хот нийтийн аж ахуйн чиглэлээр хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, сургалт сурталчилгааны ажлыг дүүргүүдийн Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлж, мэргэжил, арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангах. | Барилгын угсралт, ашиглалт болон дэд бүтцийн салбарт хууль, стандарт, нормын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд нийт 6 чиглэлээр, 17 удаагийн сургалт зохион байгуулж, 3,574 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг төлөөллийн хамруулав. Үүнд:<br>- “Барилга байгууламжийн ашиглалтын үеийн анхаарах асуудал” сэдэвт сургалтад 9 дүүргийн 610 гаруй төрийн албан хаагч, сууц өмчлөгчдийн холбоодын төлөөллийг хамруулсан.<br>- "Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нарыг чадавхжуулах" сэдэвт сургалтад 180 аж, ахуйн нэгжийн төлөөллийг хамруулсан.<br>- “Барилга байгууламжийн ашиглалт, орчны аюулгүй байдлыг хангах, инженерийн дэд бүтцийн аюулгүй ажиллагааг сайжруулах нь” сэдэвт сургалт зохион байгуулж, боловсролын байгууллагын нийт 384 төлөөлөл хамрагдав.<br>- Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийн чадавхжуулах 2 удаагийн сургалтаар захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудын нийт 330 төлөөлөл оролцсон.<br>- Даралтат сав, шингэрүүлсэн шатдаг хийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны чиглэлээр 9 удаагийн сургалт зохион байгуулж, мэргэжлийн инженер, техникийн ажилтан, байгууллагын төлөөлөл зэрэг нийт 1,552 хүнийг хамруулсан.<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Авлигатай тэмцэх газар зэрэгтэй хамтран “Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоо” сэдэвт хэлэлцүүлгийг 04 сарын 16-ны өдөр зохион байгуулж, 200 гаруй төлөөлөл оролцсон.<br>- “Цамхагт краны аюулгүй байдлыг хангах аян”-ы хүрээнд өргөх байгууламжийн оператор, инженер техникийн ажилчдад сургалтад 42 аж ахуйн нэгж байгууллагын 68 төлөөллийг хамруулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | - Зам, тээврийн яам, Монголын Авто замчдын холбоотой хамтран авто зам, замын байгууламжийн барилга угсралтын чиглэлээр 50 аж ахуйн нэгжийн 80 гаруй удирдлага, инженер, техникчдэд “Барилгын ажлын явцад илэрсэн зөрчил дутагдал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа” сэдвээр сургалт зохион байгуулсан. | |
| **Хэрэгжилийн дундаж хувь:** | | | **97.6%** |

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАЙГАЛМАА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН М.ГАЧМАА

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын
2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн
01/1006 дугаар албан бичгийн
2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025 оны 11 дүгээр сарын 28 Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Зорилт 1.1. Хот төлөвлөлт, орчны стандарт алдагдсан орон сууцны хорооллуудад газар чөлөөлөлт хийж, орчны төлөвлөлтийг стандартад нийцүүлнэ. /Алсын хараа-2050, МУЗГҮАХ-1.1.1.2, НХТЖҮЧ-9.5.2/** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1.1<br>Хот төлөвлөлтийн норм ба дүрэм зөрчсөн зөрчилд хяналт тавьж, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулж ажиллах | - | Хяналт шалгалт хийгдсэн байршлын тоо | 49 | 35 | 1. Хот байгуулалт, барилгын норм, дүрэм зөрчигдсөн үндэслэлээр Холбогдох хууль, тогтоомжийг хангуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай 35 мэдэгдлийг Хот байгуулалт, хотын стандартын газарт хүргүүлснээс 20 буюу 57% норм дүрэмд нийцүүлсэн, 15 буюу 43%-ийг дээрх байгууллагад судлагдаж байна.<br>2. Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Орон сууцны тухай хууль болон холбогдох норм ба дүрэм зөрсөн нийт 52 зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагааг явуулсан. Үүнээс Зөрчлийн хэрэг нээсэн 17, Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 32, Хэрэгсэхгүй болгосон 3 хэрэг байна. Зөрчлийн хэрэгт нийт 235.7 сая төгрөгийн торгууль ногдуулж, 138.1 сая төгрөг (58.5%)-ийг бүрэн барагдуулсан.<br>3. Хот төлөвлөлтийн норм ба дүрэм зөрчигдсөн үндэслэлээр иргэн, хуулийн | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 2 | | | | | | этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу барилгын зай хэмжээ хангахгүй 3 дүгнэлт, норм, дүрэм зөрчсөн 1 дүгнэлт, ашиглалтын шаардлага хангахгүй 3 дүгнэлт, нийт 7 дүгнэлт гарган хүргүүлсэн. | |
| 2 | Арга хэмжээ 1.1.2<br>Төрийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилгын стандартад нийцүүлэн ашиглалтад оруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Хүссэн зүг ХХК-ийн захиалгатай, 16 давхар 2 блок, үйлчилгээтэй орон сууцны барилга нь Барилгын хөгжлийн төвөөс олгосон 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн B.B-Zur-18/2024 дугаартай эрчим хүч, дулааны хэмнэлттэй, ногоон барилгын гэрчилгээтэй барилгыг ашиглалтад оруулсан. Тус барилга нь 59 хувийн эрчим хүчний хэмнэлттэй, жилд 54 тонн $CO2$ хүлэмжийн хийг бууруулах чадвартай бөгөөд дулаан эргүүлэн ашигладаг агаар сэлгэлтийн систем бүхий А ангиллын суурь шаардлагыг хангасан. Мөн ашиглалттай ногоон дээвэр болон нарны эрчим хүчийг хуримтлуулах хавтан байрлуулж зай хураагуур зэргээр тоноглогдсон хэсэгчилсэн ногоон барилгын зураг төслийн шаардлагыг хангаж баригдсан байна. | 100% |
| **Зорилт 1.2. Бохирдуулагч үйлдвэр, үйлчилгээний салбарын хаягдал усны хяналтыг сайжруулна. /МУЗГҮАХ-2.4.3.7, НЗДҮАХ-1.3.21/** | | | | | | | |
| 3 | Арга хэмжээ 1.2.1<br>Төвийн бохир усны шугам болон урьдчилсан цэвэрлэх байгууламжид бохир усаа нийлүүлж буй бохирдуулагч үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах | - | Хяналт шалгалтад хамрагдах үйлдвэрийн тоо | - | 477 | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж буй нийт 49 иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, хаягдал бохир усны бохирдлын түвшин, урьдчилсан цэвэрлэх | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | байгууламжийн суурилуулалт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллав. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд Нийслэлийн хяналт шалгалтын газраас 4 зөвлөмж, 37 албан шаардлага хүргүүлж, урьдчилан цэвэрлээгүй хаягдал усыг төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлсэн 6 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 12 сая төгрөгийн торгууль ногдуулж, ЭБАТ-ны даалгавар хүргүүлэв. Мөн зөрчил, дутагдал илэрсэн 10 аж ахуйн нэгжид Нийслэлийн Эрүүл мэндийн газраас холбогдох зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. | |
| **Зорилт 1.3. Хяналт шалгалтын цахим системийг нэвтрүүлж, шаардлагатай мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг хангана. /МУЗГҮАХ-4.1.4.1, НЗДҮАХ-5.1.8/** | | | | | | | |
| 4 | Арга хэмжээ 1.3.1<br>Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын нэгдсэн цахим системийг хөгжүүлэх | Нийслэлийн төсөв | Хяналт шалгалтын нэгдсэн цахим систем буюу application хөгжүүлэлт, хувь | 0 | 100 | Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах, ил тод байдлыг хангах, үр дүнтэй болгох зорилтын хүрээнд гар утас болон вебд суурилсан “UBInspection – Хяналт шалгалтын аппликейшн” программ хангамжийг хөгжүүлэх ажлыг гүйцэтгэхээр “Промакс” ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр гэрээ байгуулав. Уг “UB Inspection” цахим системийг хүлээн авч, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/93 дугаар тушаалаар албан ёсоор үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Мөн тус газраас нийслэлийн нутаг дэвсгэр дээрх барилгажилтын үйл ажиллагааг хянах зорилгоор Google Earth Engine платформыг ашиглан хиймэл дагуулын зураг болон хиймэл оюун ухааны загвар, шийдлүүдийг ашиглан зөвшөөрөлгүй | 70% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | барилгын ажлыг алсаас тандан илрүүлэх, хянах системийн судалгаа, туршилтын ажлыг эхлүүлсэн. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “И ТИ Креатив” ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулж, нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй барилгажилт өрнөж буй талбайн координатыг таамаглах, газрын ашиглалт, хөрсний нөхцөл байдлын өөрчлөлтийг ажиглах аргачлалыг боловсруулан туршилтын шатанд бэлтгэл ажлыг хангаж байна. | |
| **Зорилт 1.4. Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана. /МУЗГҮАХ-4.2.4.3./** | | | | | | | |
| 5 | Арга хэмжээ 1.4.1<br>Эрх бүхий байгууллагаас олгогдсон холбогдох зөвшөөрлүүдэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг хууль эрх зүйн хүрээнд арилгаж, хариуцлагыг чангатгах | - | Зөрчил арилгуулалтын хувь | - | 100 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02-00/32 дугаартай удирдамжийн дагуу Хот байгуулалт, хотын стандартын газраас 2023-2024 онд олгогдсон барилгын зөвшөөрлүүдэд хяналт шалгалт хийсэн. Барилгын ажлын зөвшөөрөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал зэрэг нийт 1610 зөвшөөрлүүдэд шалгалт хийснээс давхардсан тоогоор 581 зөрчил илрүүлсэн. Үүнд:<br>➢ Давхар талбайн харьцаа, барилга бүрхэцийн талбайг хэтрүүлэн төлөвлөсөн-148;<br>➢ Ерөнхий төлөвлөгөө, ХЕТ, бүсчлэлийн шаардлага зөрчсөн-140; | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | ➢ Газрын зориулалтыг уялдуулаагүй, зориулалтыг зөрчиж олгосон, эдэлбэр газрын хил хязгаар хэтрүүлэн төлөвлөсөн-81;<br>➢ Хот байгуулалтын тухай хуулийн 12.7 дахь хэсэг (60:40 харьцаа), 12.6 дахь хэсэг (70:30 харьцаа)-ийг тус тус хангуулаагүй. Өмнөх хуулийн үйлчлэл-62;<br>➢ Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, усан сан бүхий газрын онцгой, энгийн хамгаалалт бүсийг зөрчиж олгосон-54;<br>➢ Авто замын төлөвлөлттэй давхцуулсан, замын зурвас газрыг зөрчиж олгосон. Орц гарцны нэгдсэн төлөвлөлтгүй буюу төлөвлөөгүй-48;<br>➢ Архитектур орон зайн төлөвлөлт (барилга хоорондын зай, нарны ээвэрлэлт), хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй төлөвлөлтийг хангуулаагүй-35;<br>➢ Тусгай хамгаалалттай газарт зориулалтын бус зөвшөөрөл олгосон-8;<br>➢ Сургууль цэцэрлэгийн эдэлбэр газрын эдэлбэр газарт тавигдах шаардлагыг хангаагүй-5.<br>Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах хяналтын хуудас /02.3.1 кодтой/-аар үнэлэхэд “Дунд” эрсдэлтэй үнэлэгдэж, зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн. | |
| **Зорилт 1.5. Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна. /НХТЖҮЧ-9.5.3/** | | | | | | | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 6 | Арга хэмжээ 1.5.1<br>Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэлийн иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулах, хотын стандарт, нормыг мөрдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:<br>- Нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй байршуулсан өргөтгөл, стандартын шаардлага хангаагүй түр хашаа, түц, зар сурталчилгааны байгууламж болон бусад зөрчилтэй объектод нийт 22 албан даалгавар, 77 албан шаардлага, 91 зөвлөмж, 12 торгууль, 1 мэдэгдэх хуудас, 113 шаардах хуудас хүргүүлж, 470 байршилд хяналт шалгалт хийснээс 290 зөрчлийг илрүүлж, 99-ийг арилгуулсан.<br>- Барилгын түр хашааны стандарт хангаагүй, аюулгүй байдал алдагдсан 28 байршилд зөрчлийг арилгуулж, стандартыг мөрдүүлсэн.<br>- Нийтийн эзэмшлийн явган хүний замын төлөв байдлыг шалгаж, 7 албан шаардлага хүргүүлж, орц гарц гаргасан 2 байгууллагад 10 сая төгрөгийн торгууль ногдуулсан.<br>- Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн 7, 11, 23, 28, 30, 31 дүгээр хороодын нийт 49 байршилд хоёрдогч түүхий эд авах цэгүүд болон тос тосолгооны материал худалдаалах, авто засвар, авто угаалга, дугуй засварын үйл ажиллагаа эрхэлдэг 45 байршилд шаардах хуудас хүргүүлж, үлдсэн 4 байршилд тухайн дүүргүүдийн Газар зохион байгуулалтын албанаас мэдэгдэх хуудас хүргүүлэв.<br>- Ахуйн хог тээвэр, нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ эрхлэгч 20 | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | байгууллагын 298 тээврийн хэрэгсэл, 17 зогсоол, 17 засварын байрт хяналт шалгалт хийж, 214 зөрчил илрүүлэн 20 албан шаардлага хүргүүлсэн.<br>- Эмнэлгийн гадна орчны аюулгүй байдлыг шалгаж, 20 байгууллагад хяналт хийж, 14-д хугацаатай үүрэг өгч зөрчлийг 90 хувьтай арилгасан.<br>- Хүн амын нягтаршил ихтэй бүсэд байрлах 50 ШТС, 3 АХЦС-ыг хамруулсан шалгалт хийж, 53 албан шаардлага, 10 заалт бүхий 7 албан даалгавар хүргүүлж биелэлтэд хяналт тавьж ажиллав.<br>- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан 18 байгууллагуудад ашиглалт үйлчилгээг сайжруулах талаар мэдэгдэл хүргүүлсэн.<br>- 2024, 2025 он дамжин хэрэгжиж буй авто зам, замын байгууламжийг сэтэлж, сүвлэх зөвшөөрөл олгосон 73 байршлын нөхөн сэргээлтийг хийх тухай албан шаардлагыг Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д хүргүүлэв.<br>- “Дуу чимээний бохирдол” хотын стандартыг хэрэгжүүлэх ажлын шөнийн цагаар барилга угсралтын ажил гүйцэтгэхтэй холбоотой зөвлөмжийг 168 байгууллагад хүргүүлж, дуу чимээ гаргасан талаарх гомдлын тоо буурсан үзүүлэлттэй байна. | |
| **Зорилт 1.6. Цагдаа, түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагаа шуурхай хүрэх, нэвтрэх боломжийг бүрдүүлж гэр хороолол болон зуслангийн бүсийн орц, гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийг арилгана. /НЗДҮАХ 1.2.22./** | | | | | | | |
| 7 | Арга хэмжээ 1.6.1<br>Орон сууцны хотхон, хорооллын орц, гарц хаагдсан хэсгийн | - | Зөрчил арилгуулсан байршлын тоо | - | 15 | Орон сууцны хотхон, хорооллын орц, гарц хаагдсан зөрчлийг арилгах ажлын хүрээнд нийт 25 байршилд хяналт шалгалт хийж, 13 | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | зөрчлийг арилгаж, хариуцлага тооцох | | | | | байршилд орц, гарц хаагдсан зөрчлийг арилгуулж, бусад байршлуудад зөрчлийг арилгуулах талаар холбогдох байгууллагуудад мэдэгдэл, шаардлага хүргүүлэв. Үүнд:<br>➢ Нийслэлийн Засаг даргын А/237 дугаар захирамжийн хүрээнд орон сууцны хотхон, хорооллын орц, гарц хаагдсан зөрчлийг арилгах хяналт шалгалтыг зохион байгуулж, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдэд зөвшөөрөлгүй орц, гарц хаасан 4 зөрчлийг илрүүлэн Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд шилжүүлэв.<br>➢ Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо “Эвэл Апартмент” хотхон, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо “Мандала” орон сууцны хотхонд авто зогсоолын орц, гарцын норм, стандартын хэрэгжилтийг хангуулав.<br>➢ Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 73, 184 дүгээр сургуулийн орц, гарц хаагдсан асуудалд хяналт шалгалтыг хийж, зөрчлийг арилгах талаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Онцгой байдлын газарт мэдэгдэв.<br>➢ Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо, Билгүүн бар ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн ажилд шалгалт хийж, гадна тохижилт, авто зам, орц, гарцын асуудлыг шийдвэрлэх албан шаардлага хүргүүлэв.<br>➢ Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, “Магнет Импорт” барилгын материалын | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хуурай хольцийн үйлдвэрийн үйл ажиллагааг төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар зогсоож, суурьшлын бүсээс нүүлгэн орц, гарцыг чөлөөлсөн.<br>➢ Хан-Уул дүүргийн 22 дугаар хороо, Сарнайх дэлгүүр, Спарк цэцэрлэгийн барилгын явган хүний зам, замын гарцыг хаасан зөрчлийг арилгуулсан.<br>➢ Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар хотхон, хорооллын орц, гарц хаасан 15 байршилд хяналт хийж, “Орц гарцыг нээх тухай” 24 заалт бүхий 8 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан бөгөөд 7 байршилд албан бичгээр мэдэгдэл хүргүүлж шийдвэрлэсэн. | |
| **Зорилт 1.7. Шинээр болон өргөтгөн шинэчлэх 257 км авто зам, замын байгууламжийг ус зайлуулах сүлжээтэй барьж байгуулан усанд автдаг байршлуудын тоог бууруулна. /НЗДҮАХ 1.3.11./** | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ 1.7.1<br>Нийслэлийн хэмжээнд шинээр хийгдэж буй авто зам, замын байгууламжийн төсөл, арга хэмжээнд төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах | - | Шалгалтад хамрагдах төсөл арга хэмжээ, тоо | - | 4 | Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны “Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” 04/05 дугаар удирдамжийн хүрээнд дараах төслүүдэд хяналт шалгалт хийв. Үүнд:<br>1) Дүүжин тээврийн төслийн барилга угсралтын ажилд шалгалт хийж, барилгын түр хашаа, орчны аюулгүй байдлыг хангуулах, дутагдлыг арилгуулах талаар гүйцэтгэгч Моннис инженеринг ХХК-д албан шаардлага хүргүүлэв.<br>2) Сонгинохайрхан дүүргийн Соёлын төвийн урд хэсгийн авто замын угсралтын ажлыг шалгаж, батлагдсан зураг төсөл зөрчиж авто замын зорчих хэсгийн цахилгааны тулгуур шилжүүлэхгүйгээр асфальтбетон | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хучилт хийсэн “Баян-Өлзийт зам” ХХК-д Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч, зөрчил арилгах албан даалгавар хүргүүлэв.<br>3) Баянзүрх дүүрэг Сансарын үйлчилгээний төв орчмын тохижилтын ажлыг шалгаж, илэрсэн дутагдлыг арилгуулахаар гүйцэтгэгч “Морин сувд” ХХК-д албан шаардлага хүргүүлэв.<br>4) Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, 46 байрны ард авто машины зогсоол шинээр байгуулах ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийв.<br>5) Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Эрчим хүчний гудамжны авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын зураг төсөл, холбогдох баримт бичиг, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг шалгаж, зөвлөмж өгөв. | |
| **Зорилт 1.8. Үер, усны эрсдэлтэй бүсийг тогтоож, үүнд өртөж байгаа гэр хорооллын айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлж чөлөөлөх, <u>хөрсний усны нэвчилттэй байшин барилгуудын суурийн хийцлэлд хүчитгэсэн хамгаалалтыг хийх,</u> голын ай сав газрын дагуу ус зайлуулах нэгдсэн сүлжээнд холбох, шүүрүүлэх худаг байгуулах зэрэг инженерийн шугам хоолойн нэгдсэн шийдэл гаргаж иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулна. /НЗДҮАХ 1.3.12/** | | | | | | | |
| 9 | Арга хэмжээ 1.8.1<br>Ашиглагдаж буй барилга байгууламжийн хөрсний усны нэвчилтийн байдалд хяналт шалгалт хийж эрсдэлийг бууруулах | - | Эрсдэлийг бууруулсан хувь | - | 100 | Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Хот байгуулалт, Хотын стандартын газар, Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-аас гаргасан судалгаагаар гаргасан нийслэлийн төвийн зургаан дүүргүүдэд байрладаг хотхон хорооллуудын хур бороон ус ихээр тогтдогт нийт 38 байршилд Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 02-13-04/023/25 дугаартай удирдамжийн дагуу | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хяналт шалгалт хийж, 8 байршилд зөрчлийг арилгуулав. Шалгалтын танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналыг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/1045 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Улаанбаатар Захирагчийн ажлын алба, Хот байгуулалт, Хотын стандартын газар, Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлэв. | |
| **Зорилт 1.9. Ундны усны эх үүсвэрийн бүсийн дэглэмийг мөрдүүлж, Баруун эх үүсвэрийг ашиглалтад оруулна. /НЗДҮАХ 1.3.14/** | | | | | | | |
| 10 | Арга хэмжээ 1.9.1<br>Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчилд хариуцлага ногдуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Яармаг орчмын ундны усны эх үүсвэрт холбогдсон шугам сүлжээнээс зэвтэй ус гарч байсныг шалгах ажлын хэсгийн шийдвэрийн дагуу Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 10, 16, 23, 24 дугаар хороодын усны шугамыг HDPE хуванцар хоолойгоор сольж, байнгын ашиглалтад хүлээн авсан. | 50% |
| **Зорилт 1.10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог олон улсын стандартад нийцүүлэн өөрчилнө. /НЗДҮАХ 2.3.2, НХТЖҮЧ-9.5.1/** | | | | | | | |
| 11 | Арга хэмжээ 1.10.1<br>Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийн төлөвлөлтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх | - | Стандартад нийцсэн барилга байгууламжийн тоо | 646 | 200 | Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Салбарын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/06 дугаартай удирдамжийн дагуу орон сууц, олон нийтийн 450, сургууль цэцэрлэгийн 160, нийт 610 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, ашиглалтын чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтын | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | үр дүнд Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 02-13-01/033/48 дугаартай “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн барилга байгууламжид тавигдах шаардлага, аюулгүй байдлыг хангуулах тухай” зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг чиглэл өгөв. | |
| 12 | Арга хэмжээ 1.10.2<br>Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартад нийцүүлж, ашиглалтад оруулах (Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй төлөвлөлт) | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 350 барилга байгууламжийг ашиглалтад авах комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагын оролцоог бүрэн хангаж ажиллалаа. Үүнээс нийгмийн үйлчилгээний зориулалттай дараах 51 барилгад дээрх байгууллагын төлөөлөл оролцож, барилгын гадна, дотор орчныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан стандартын дагуу болгох үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулж ажиллав. Үүнд:<br>➢ Сургууль, цэцэрлэгийн цогцолбор – 5;<br>➢ Сургууль – 17;<br>➢ Цэцэрлэг – 13;<br>➢ Эмнэлэг – 10;<br>➢ Хорооны цогцолбор – 6. | 100% |
| **Зорилт 1.11. Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, хараат бус, үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. /НЗДҮАХ 5.1.7/** | | | | | | | |
| 13 | Арга хэмжээ 1.11.1<br>Төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг ижил түвшний эрх зүйн тогтолцоо бүхий улс орны хяналтын тогтолцооны судалгаа хийх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг бусад ижил түвшний эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудын хяналтын тогтолцоотой харьцуулсан судалгаа хийх ажлын хүрээнд Герман, Япон, Швейцарь, | 90% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Сингапур, Өмнөд Солонгос, Норвеги, Австрали, Бүгд Найрамдах Хорват зэрэг ул орнуудын барилгын хяналтын тогтолцоог ерөнхий чиглэлээр судлав. Тус судалгааны хүрээнд Монгол Улсын төрийн хяналт шалгалтын эрх орчныг Ром-Германы эрх зүйн бүл бүхий дараах улс орны эрх зүйн орчинтой харьцуулсан судалгааг хийсэн. Үүнд:<br>• Бүгд Найрамдах Солонгос Улсын төрийн хяналт, барилгын хяналтын тогтолцоо, эрх зүйн орчин-Аудит болон хяналт шалгалтын тухай хууль (Board of Audit and Inspection Act), Барилгын хууль (Building act)<br>• Бүгд Найрамдах Словень улсын төрийн хяналт шалгалтын тогтолцоо, эрх зүйн орчин- Хяналт шалгалтын тухай хууль (Inspection act of Slovenia) | |
| 14 | Арга хэмжээ 1.11.2<br>Хяналт шалгалтын үр дүн, үр нөлөөг сайжруулах хүрээнд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг боловсруулж, уламжлах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | - Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 сарын 04-ний өдрийн А/1459 дүгээр захирамжаар хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах санал зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам зэрэг нийт **6 хууль тогтоомжийн 24 зүйл, заалтад** нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, танилцуулгын хамт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/186 дугаартай | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.<br>- Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Нийслэлийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулагдаж, тус газрын удирдлага ажлын хэсгийн ахлагчаар томилогдсон. Ажлын хэсгийн хүрээнд **8 хууль тогтоомжийн 36 зүйл, заалтад** нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/890 дугаартай албан бичгээр НИТХ-д, мөн 01/891 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлсэн. | |
| **Зорилт 1.12. Хяналтын чиг үүргийн байгууллагын харьяанд туршилт шинжилгээний дэвшилтэт технологи бүхий итгэмжлэгдсэн лабораторийг өргөжүүлж, чадамжийг дээшлүүлнэ. /НЗДҮАХ 5.1.9/** | | | | | | | |
| 15 | Арга хэмжээ 1.12.1<br>Барилгын болон автозамын материал, хийц, бүтээц, эзлэхүүний шинж чанарыг тодорхойлох, газрын тос, хийн үзүүлэлтийг хэмжих, сорилт шинжилгээний лаборатори байгуулах бэлтгэл ажлыг хангуулах | Нийслэлийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 0 | 30 | Барилгын болон автозамын материал, хийц, бүтээц, эзлэхүүний шинж чанарыг тодорхойлох, газрын тос, хийн үзүүлэлтийг хэмжих, сорилт шинжилгээний иж бүрэн лаборатори байгуулах төслийн хүрээнд шаардлагатай дагалдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, судалгааны үндэслэл болон урьдчилсан төсвийн тооцоог нэгтгэн боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/84 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний | 50% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | төлөвлөгөө"-нд тусгасан энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг 2026 оны төсөвт тусгуулж, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 01/1149 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд улсын төсвийн орлого бүрдэлтээс шалтгаалан зардлын зарцуулалтын эрх нээгдэхгүй байгаатай холбоотойгоор тус зардлыг санхүүжүүлэх боломжгүй гэсэн хариуг тус газраас ирүүлээд байна. | |
| **Зорилт 1.13. Шинэ Төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, Лаг хатаах шатаах байгууламж, шаардлага хангасан юүлэх станцын ажлыг эхэлнэ. /НХТ/** | | | | | | | |
| 16 | Арга хэмжээ 1.13.1 "Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавх бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд хаягдал устай холбоотой нэгдсэн удирлага зохицуулалтын менежментийг сайжруулах, хяналт шалгалт, зөвлөх ажлыг бохирдуулагч үйлдвэрийн ангилал бүрээр зохион байгуулж ажиллах | - | Төслийн хэрэгжилт | 30 | 100 | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж буй нийт 49 иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, хаягдал бохир усны бохирдлын түвшин, урьдчилсан цэвэрлэх байгууламжийн суурилуулалт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллав. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд Нийслэлийн хяналт шалгалтын газраас 4 зөвлөмж, 37 албан шаардлага хүргүүлж, урьдчилан цэвэрлээгүй хаягдал усыг төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлсэн 6 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 12 сая төгрөгийн торгууль ногдуулж, ЭБАТ-ны даалгавар хүргүүлэв. Мөн зөрчил, дутагдал илэрсэн 10 аж ахуйн нэгжид Нийслэлийн Эрүүл | 100% |
| | | | Нэгж байгуулах ажлын явц | 10 | 100 | | |
| | | | Хяналт шалгалт, зөвлөх ажлын явц | - | 100 | | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | мэндийн газраас холбогдох зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. | |
| **Зорилт 1.14. Барилга, дэд бүтцийн төрийн хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулж, улсын байцаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ. /НХТ/** | | | | | | | |
| 17 | Арга хэмжээ 1.14.1<br>Улсын /ахлах/ байцаагчдыг мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөр баталж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлэх | Нийслэлийн төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэлийн хэмжээнд барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналтын улсын (ахлах) байцаагчдын чадавх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тус газрын 42 улсын байцаагчийн мэргэшлийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, холбогдох яам, мэргэжлийн холбоод болон сургалтын байгууллагуудын судалгаанд үндэслэн мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөрийг боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлөвлөгөө гарган дараах сургалтуудад улсын (ахлах) байцаагчдыг хамруулав. Үүнд:<br>1) Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын хяналтын чиглэлийн сургалт: 2025 оны 02 дугаар сарын 10-нд цахимаар, 13–14-нд танхимаар зохион байгуулагдаж Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн 18 байцаагч, албан хаагч хамрагдав.<br>2) “Барилгын эрчим хүчний үр ашиг” сургалт (RePaRe төсөл, GIZ/ГОУХАН): 2025 оны 03 дугаар сарын 15, 16, 22, 23-нд зохион байгуулагдаж нийт 26 албан хаагч хамрагдсан.<br>3) Нийслэлийн Прокурорын газартай хамтарсан сургалт: “Зөрчлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр 2025 оны 03 дугаар | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | сарын 27-нд зохион байгуулагдаж, 30 албан хаагч хамрагдав.<br>4) “Барилгын эрчим хүчний хэмнэлтийн үр ашиг” 32 цагийн сургалт (RePaRe төсөл, МБЗТСХ): 2025 оны 03 дугаар сарын 15-23-нд зохион байгуулагдаж, 28 байцаагч, албан хаагч мэргэжил дээшлүүлж, 3 багц цагийн гэрчилгээ авсан.<br>5) Угсармал бетон хийцлэлтэй танилцах дадлага сургалт: 2025 оны 09 дүгээр сарын 18-нд “Эн Си Ди Прекон” ХХК-тай хамтран Каса да Винчи болон Гарден сити хаус төслийн талбайд зохион байгуулж, НХШГ-ын улсын (ахлах) байцаагчид оролцов. | |
| **Зорилт 1.15. Нийслэлд баригдаж байгаа барилга байгууламжийн үерийн болон борооны усыг төлөвлөлтийн дагуу зайлуулах шугам сүлжээг 5 хувиар нэмэгдүүлэн, байгууламжийг шинээр бий болгож, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ. /НХТ/** | | | | | | | |
| 18 | Арга хэмжээ 1.15.1<br>Үер, борооны усыг хуримтлуулах, зайлуулах талаар барилга байгууламж, авто замын зураг төсөл, бүтээн байгуулалтын ажилд мөрдүүлэх хотын стандартын төсөлд санал өгч, хамтран ажиллах | - | Боловсруулах хотын стандарт | - | 3 | Хот байгуулалт, хотын стандартын газрын https://uds.ub.gov.mn/standard цахим хуудсаар дамжуулан Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтад тавигдах шаардлага хотын стандартын төсөлд-3, Хотын авто зам төсөллөх ерөнхий шаардлага хотын стандартын төсөлд-2, Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага стандартын төсөлд-1 нийт 6 санал боловсруулан хүргүүлэв. | 100% |
| **ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Зорилт 2.1. Газрын үндсэн чиг үүргийн хүрээнд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад уламжилна.** | | | | | | | |
| 19 | Арга хэмжээ 2.1.1<br>Салбарын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, хэм хэмжээний акт, норм ба дүрэм, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Дээд шатны байгууллагаас ирүүлсэн дараах хууль тогтоомж болон холбогдох дүрэм, журмын төслүүдэд санал боловсруулан хүргүүлэв. Үүнд:<br>➢ Барилгын ерөнхий хуулийн төсөл; | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | стандартад болон холбогдох төсөлд санал хүргүүлэх | | | | | ➢ Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл;<br>➢ Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл;<br>➢ Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;<br>➢ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль;<br>➢ Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрэм;<br>➢ Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам;<br>Түүнчлэн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд салбарын чиг үүрэгт хамаарах дараах дүрэм журам, албан бичиг, нөлөөллийн шинжилгээг боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэв. Үүнд:<br>➢ Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/1227 дугаартай албан бичиг–ээр “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын ажиллах зардлын жишиг хэмжээг барилга байгууламжийн төвөгшил, хэмжээг харгалзан тогтоох тухай” албан бичгийг боловсруулж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хүргүүлсэн;<br>➢ “Барилгын үйл ажиллагааны аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”-ын нөлөөллийн шинжилгээг боловсруулж, | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн;<br>➢ Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж, олон нийтээс санал авах зорилгоор байгууллагын цахим хуудас www.inspection.ub.gov.mn-д байршуулсан. | |
| 20 | Арга хэмжээ 2.1.2<br>Барилга, дэд бүтцийн болон бусад салбарын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийг боловсруулж, дээд шатны байгууллагад уламжлах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 100 | Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийн төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэв. Хөтөлбөрийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхээр болов. | 100% |
| 21 | Арга хэмжээ 2.1.3<br>Нийслэлийн хэмжээнд мөрдөгдөх “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргад өргөн мэдүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 100 | Барилгын ажил гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, барилгын талбай болон түүний гаднах эрсдэлтэй бүсийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор “Нийслэл дэх барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагуудаас санал авч нэгтгэн, нөлөөллийн шинжилгээний хамт 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 01/242 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 22 | Арга хэмжээ 2.1.4<br>Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дотоод дүрэм, журмыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах | - | Дүрэм, журмын тоо | - | 3 | Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлуулсан. Мөн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор “Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх журам”-ыг шинэчлэн батлуулахаар хянан нийцүүлэлт хийж байна. | 90% |
| 23 | Арга хэмжээ 2.1.5<br>Байгууллагын албан хаагчдад эрх зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Байгууллагын албан хаагч, эрх бүхий албан тушаалтнуудад үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд хууль, эрх зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажилласан. Үүнд:<br>- барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаа;<br>- зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа;<br>- Хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдад тушаал, шийдвэр боловсруулахтай холбоотой;<br>- Дотоод хяналт, шинжилгээний хэлтст дээд шатны болон хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн гомдол шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагаа;<br>- компанийн эрх зүй, төлөөлөл;<br>- зөвшөөрөлгүй, удаа дараа гомдол ирүүлдэг, маргаантай барилга, объектын талаар.<br>Мөн байгууллагын нийт албан хаагчдыг эрх зүйн мэдлэгээр хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор дараа 4 сургалтыг зохион байгуулсан. Үүнд:<br>1. “Хяналт шалгалтын эрх зүйн орчин ба сайжруулах хэрэгцээ, шаардлага” | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | сэдэвт сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 06-нд;<br>2. “Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг” сэдэвт сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 02-нд;<br>3. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлигаас урьдчилан сэргийлэх нь: Анхаарах асуудал” сэдэвт сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 04-нд;<br>4. “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, анхаарах асуудал” сэдэвт сургалт 2025 оны 10 дугаар сарын 21-нд тус тус зохион байгуулав. | |
| 24 | Арга хэмжээ 2.1.6<br>Хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг Нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд байгууллагыг шүүхэд төлөөлөх үүргийг хэрэгжүүлж, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг төлөөлж нийт 16 хэрэг, маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хууль тогтоомжийн дагуу оролцсон. Үүнд:<br>1. Бүрэн цутгамал ХХК;<br>2. Иргэн Р.Адъяасүрэн;<br>3. Юу ди трэйд ХХК;<br>4. Хүчит чулуут ХХК;<br>5. Паркнайн ХХК;<br>6. Монгол Угсаа Констракшн ХХК;<br>7. Ломекс ХХК;<br>8. Ач очир ХХК;<br>9. Эрчим СӨХ;<br>10. Эм ти эс ХХК;<br>11. Д.Ундрахсан С.Базарваань нар;<br>12. Иргэн Баттогтох;<br>13. Монос Хүнс ХХК; | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | 14. Баганат өргөө ХХК;<br>15. Иргэн Даваадолгор;<br>16. Иргэн Баасандорж.<br>Үүнээс:<br>➢ Бүрэн шийдвэрлэгдсэн маргаан: 9<br>○ Нэхэмжлэгчийн талд шийдвэрлэгдсэн: 4 (44.4%)<br>○ Хариуцагчийн талд шийдвэрлэгдсэн: 5 (55.5%)<br>➢ Хянан шийдвэрлэгдэх шатанд байгаа маргаан: 7 | |
| **Зорилт 2.2. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох ажиллагааг зохион байгуулна.** | | | | | | | |
| 25 | Арга хэмжээ 2.2.1<br>Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн нэгдсэн бүртгэл хөтөлж, нийслэлийн Прокурорын газрын niislelprozurchil/@gmail.com цахим хаягаар хуулийн хугацаанд хүргүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн нийт 369 бүртгэл хөтөлж, Нийслэлийн Прокурорын газрын niislelprozurchil@gmail.com цахим хаягаар нэгдсэн бүртгэлд хүргүүлсэн. | 100% |
| 26 | Арга хэмжээ 2.2.2<br>Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авах | - | Зөрчил арилгуулалтын хувь | - | 100 | Тус газарт барилга, дэд бүтцийн салбарт хамаарах 369 зөрчлийн тухай гомдол, мэдээлэл бүртгэгдсэний дагуу Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулан дараах шийдвэрийг гаргаж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хариуцлага оногдуулан ажиллав. Үүнд:<br>➢ Зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн-29;<br>➢ Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн-324;<br>➢ Харьяаллын дагуу шилжүүлсэн-6;<br>➢ Хэрэгсэхгүй болгосон-6;<br>➢ Хүлээн авахаас татгалзсан-4. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад нийт 867 сая төгрөгийн торгууль ногдуулсан. | |
| **Зорилт 2.3. Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хуулийн дагуу хянан баталгаажуулах үйл ажиллагааг 2 чиглэлээр явуулна.** | | | | | | | |
| 27 | Арга хэмжээ 2.3.1<br>Өргөх механизмын техникийн магадлал, баталгаажуулалт хийж улсын бүртгэлд хамруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 528 ширхэг лифтэнд бүрэн магадлал хийж, Барилгын тухай хуулийн 47.2.8 дахь заалтын дагуу өргөх байгууламжийн нэгдсэн бүртгэлд нийт 680 өргөх байгууламжийг шинээр бүртгэж оруулав. Үүнд:<br>➢ Автокран - 51,<br>➢ Цамхагт кран -18,<br>➢ Гүүрэн кран - 6,<br>➢ Лифт - 277,<br>➢ Урсдаг шат - 38,<br>➢ Барилгын дүүжинт өргүүр - 134,<br>➢ Ачаа хүн зөөврийн өргүүр - 8,<br>➢ Манипуляторт кран - 108,<br>➢ Сагстай өргөгч - 36,<br>➢ Бетон зуурмагийн шахуургат төхөөрөмж - 4. | 100% |
| 28 | Арга хэмжээ 2.3.2<br>Зуух, даралтат сав, шугам хоолойн техникийн магадлал, баталгаажуулалт хийж, бүртгэлд хамруулах | - | Баталгаажуулал-тад хамрагдсан зуух, даралтад сав шугам хоолой | - | 10 | "Зорчигч тээвэр нэг" ОНӨААТҮГ-ийн 1, “Эко Тэлмэн Од” ХХК-ийн 3, “Сайхан Төмөрт” ХХК-ийн 1, “Монос” ХХК-ийн 1, “Очирдагинас” ХХК-ийн 5, “Би Цэ Трейд” ХХК-ийн ашиглаж буй 10, “Витафит Инвест” ХХК-ийн 18, мөн 100 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын 11 зуух, нийт 50 зуух, даралтат сав, шугам хоолойн техникийн магадлалд баталгаажуулалт хийсэн. Мөн шаардлага хангаагүй 1 даралтат савыг ашиглалтаас хассан. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 2.4. Төсөв, санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэл хяналт тавих, орлогын төлөвлөгөөг биелүүлж, үр дүнг тайлагнах, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангаж ажиллана.** | | | | | | | |
| 29 | Арга хэмжээ 2.4.1<br>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах | 4,258,994.1 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл “Төсвийн цаглавар”-ын дагуу сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ, улирал бүр санхүүгийн болон татварын тайланг хугацаанд нь үнэн зөв гарган, холбогдох байгууллагуудаар баталгаажуулан ажиллав. 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар байгууллагын батлагдсан төсвийн гүйцэтгэл 74,25 хувийн хэрэгжилттэй байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/87 дугаар албан бичгээр хүргүүлсэн "2025 оны төсвийг нэмэгдүүлж тодотгол хийлгүүлэх тухай" хүсэлтийн дагуу, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/552 дугаар захирамжаар тус байгууллагын төсвийг 218.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, холбогдох ажлыг хэрэгжүүлэн ажиллав.<br>Төсвийн гүйцэтгэлийн 2025 оны 11 дүгээр сарын мэдээгээр байгууллагын батлагдсан төсөв 3,371,472.7 мянган төгрөг, гүйцэтгэл 2,894,740.5 мянган төгрөг буюу 85.9 хувьтай байна. Нэмэлт санхүүжилтээр НГХУССЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 346,786.5 мянган төгрөгийг зарцуулсан. Төсвийн тухай хуулийн “8 дугаар зүйл.Төсвийн цаглавар”-ийн дагуу төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ (10 удаа), санхүүгийн тайланг (3 удаа) хуулийн хугацаанд үнэн зөв гарган Нийслэлийн санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж тайлагнан ажилласан. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 30 | Арга хэмжээ 2.4.2<br>Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн саналыг хууль тогтоомжид заасан хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | 2026 оны төсвийн төсөл 2027-2028 оны төсвийн төсөөллийн саналыг боловсруулан 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 01/687 дугаар албан бичгээр, мөн төсвийн төсөлд хяналт шалгалтын чиглэлээрх зардлын нэмэлт санал боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 01/1012 дугаар албан бичгээр тус тус Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэв. | 100% |
| 31 | Арга хэмжээ 2.4.3<br>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган, байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн мэдээллийг https://shilendans.gov.mn/ цахим системд тухай бүр тайлагнах | - | Байршуулах мэдээллийн тоо | 72 | 73 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган, байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн мэдээллийг https://shilendans.gov.mn/ цахим системд тухай бүр байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган олон нийтэд мэдээлж, төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. 2025 оны 10 дугаар сарын байдлаар шилэн дансанд байршуулах 135 мэдээллийг бүрэн (100%) байршуулсан бөгөөд үүнээс 130 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна. | 90% |
| 32 | Арга хэмжээ 2.4.4<br>Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль, шийтгэврийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх | - | Хүү торгуулийн орлого, сая төгрөг | 543.7 сая | 400.0 сая | 2025 онд Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль, шийтгэврийн 400.0 сая төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар нийт 634.0 сая төгрөгийг НЗДТГ-ын Төрийн сангийн дансанд төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 160 хувиар биелүүлсэн. Энэхүү орлогод холбогдох анхан шатны баримт болох Зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн шалтгаан бүхий шийтгэлийн хуудас (маягт 1, маягт 2)-ыг бүрдүүлж, | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсвийн орлогын ахлах мэргэжилтэнд хүргүүлэн ажиллав. | |
| **Зорилт 2.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулна.** | | | | | | | |
| 33 | Арга хэмжээ 2.5.1<br>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах, үнэлгээний хороог байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | “Хяналт шалгалтын газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр газрын даргаар батлуулав. Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/38 дугаарын тушаалаар “Үнэлгээний хороо”-г байгуулж, 7 төрлийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, шалгарсан байгууллага, ААН-тэй гэрээ байгуулан худалдан авалтыг хийж, тайлагнан ажилласан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд харьцуулалтын аргыг хэрэглэн байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, шууд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | 100% |
| 34 | Арга хэмжээ 2.5.2<br>Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем | - | Цахим системд тайлагнах төсөл, арга хэмжээ | - | 100 | Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/552 захирамжаар төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан “Хяналт шалгалтын газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр газрын даргаар батлуулан, tender.gov.mn цахим системд нийтэлсэн. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнах | | | | | | |
| 35 | Арга хэмжээ 2.5.3<br>Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, актлах, үнэлгээний үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. Батлагдсан төсвийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, үндсэн хөрөнгө болон хангамжийн материалыг актлах, засвар үйлчилгээний зардлыг зөв зохистой зарцуулахад хяналт тавьж, холбогдох шийдвэрүүдийг гаргасан. Тухайлбал, Зөвлөлийн бүрэлдэхүүн нийт 12 удаа хуралдаж, 8 дүгнэлт гарган Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлэн ажиллав. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар ирүүлсэн хүсэлтийн дагуу тус газрын өмчид бүртгэлтэй нийт 50 нэр төрлийн 289 ширхэг тавилга, эд хогшлын 243,918,781.41 төгрөгийн хөрөнгийг “Актлах дүгнэлт” хүргүүлж, хөрөнгийг хүлээлгэн өгөх үйл явцад хяналт тавин ажилласан. Мөн Нийслэл дэх Төрийн аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хүрээнд тооллогын комиссын актлах саналд үндэслэн газрын бүртгэлд буй 71-02 УАЕ, 71-09 УАЕ улсын дугаартай Toyota Prius маркийн 2 автомашиныг актлах асуудлыг зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн. Байгууллагын эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 243,918,781,41 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 159 төрлийн 285 ширхэг актлагдсан эд хөрөнгийг данс бүртгэлээс хасан, түүнтэй холбоотой эд хариуцагчийн бүртгэлд өөрчлөлт оруулсан. | |
| **Зорилт 2.6. Байгууллагын үйл ажиллагааг хүний нөөцийн удирдлагаар хангах, мэргэшсэн төрийн албан хаагчаар хангах, нөөцийн хэрэгцээг тогтоох, төлөвлөх, сургалтыг тодорхойлж хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 36 | Арга хэмжээ 2.6.1<br>Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх | Батлагдсан төсвийн хүрээнд | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | 100 | Нийслэлийн Хяналт шалгалтын газрын албан хаагчдын амьдралын нөхцөл, ажиллах орчин, нийгмийн баталгаа, тулгамдсан асуудал, ирээдүйн хэрэгцээг тодорхойлоход чиглэгдсэн судалгааг нийт 61 албан хаагчийг хамруулан 6 бүлэгт хуваан нийт 31 асуултаар явуулсан. Судалгааны үр дүнд үндэслэн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулав. “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:<br>➢ Удирдлагын академийн 2025 оны сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу Төрийн албаны тухай холбогдох хууль тогтоомжид заасан дараах, төрлийн сургалтад 5 албан хаагч хамрагдсан. Үүнд: Төрийн албанд анх томилогдсон албан | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт-2, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт-1, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалт-2 албан хаагч тус тус хамрагдсан.<br>➢ Салбарын чиглэлээр 5 албан хаагч магистрын сургалтад хамрагдсан.<br>➢ Мэргэшсэн архитектор, инженер, төсөвчин зэргийг сунгах, зөвлөх архитектор, инженер, тэргүүлэх төсөвчин зэргийг горилох, сунгах сургалтад тус газрын 5 албан хаагч хамрагдсан.<br>➢ Албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх хүрээнд гадаадын 5 удаагийн сургалт, зөвлөгөөний хөтөлбөрт нийт 28 албан хаагчийг хамруулан мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэн ажиллав.<br>➢ Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр гадаадын сургалт, зөвлөгөөний хөтөлбөрт 5 удаа, нийт 28 албан хаагч хамрагдсан.<br>➢ Байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад хамруулах<br>➢ Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/578 дугаар захирамжийг үндэслэн газрын даргын тушаалаар 10 албан хаагчид төрийн захиргааны албан хаагчдад олгох зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгов.<br>➢ 3 албан хаагчид мэргэшсэн инженерийн нэмэгдлийг олгуулав. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | ➢ Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 02 дугаар сарын 12-14-ний өдөр нийт 50 албан хаагчийг “Эрт илрүүлэг” шинжилгээнд хамруулав.<br>➢ Монос ХХК-тай хамтран “Эрүүл мэндийн өдөрлөг” нээлттэй арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, эрдсийн шинжилгээ, арьс оношилгоо, ясны сийрэгжилт, шүдний эмчийн үзлэг гэсэн 4 төрлийн эрүүл мэндийн үзүүлэлтээр оношилгоог хийсэн.<br>➢ НЗДТГ-ын даргын А/185 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалын орон сууцанд хамрагдсан оршин суугчдын дагаж мөрдөх журам”-ыг танилцуулж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/531 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Уг хөтөлбөрт хамрагдсан 4 албан хаагчийн 2 нь эхний ээлжийн орон сууцанд хамрагдаж, үлдсэн 2 албан хаагч нь дараагийн ээлжинд хамрагдахаар хүлээгдэж байна. | |
| 37 | Арга хэмжээ 2.6.2<br>Албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг батална, хэрэгжүүлэх | Батлагдсан төсвийн хүрээнд | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 100 | Байгууллагын албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 2025 оны сургалтын төлөвлөгөөг 7 бүлгийн хүрээнд нийт 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр нэгтгэн удирдлагад танилцуулсан бөгөөд | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | нийт 38 арга хэмжээ 99.47 хувьтай хэрэгжсэн байна. | |
| 38 | Арга хэмжээ 2.6.3<br>Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулж, батлуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/63 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолт боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай”-ын дагуу нийт 50 албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулж дууссан. Үүнд:<br>➢ шинээр батлуулах-11,<br>➢ өөрчлөн батлуулах (байгууллагын нэр өөрчлөх)-37,<br>➢ хэлтсийн нэр өөрчлөн батлуулах-2.<br>Одоогоор өмнө батлагдсан албан тушаалын тодорхойлолттой харьцуулсан харьцуулалт, бүтцийн харьцуулалтыг хийсэн ба чиг үүргийн шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтын төслийн танилцуулгыг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. | 90% |
| 39 | Арга хэмжээ 2.6.4<br>Хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, сул орон тоог нөхөн бүрдүүлэх, сонгон шалгаруулалт зохион байгуулж байгууллагын үйл ажиллагааны | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | - Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой нийт 124 Б тушаал боловсруулж, баталгаажуулан ажиллав. Үүнд:<br>➢ Ажилд томилсон – 65,<br>➢ Ажлаас чөлөөлсөн – 26,<br>➢ Сахилгын шийтгэл оногдуулсан – 8, | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | жигд тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах | | | | | ➢ Чөлөө олгосон – 6,<br>➢ Нэмэгдэл олгох тухай – 10,<br>➢ Бусад – 8.<br>- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын сул орон тоог бүрдүүлэх хүрээнд төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн авах зарыг UB ERP системд 3 удаа байршуулан, материалаа ирүүлсэн 28 албан хаагчидтай сонгон шалгаруулалтын ярилцлагыг зохион байгуулав. Төрийн албаны тухай хууль болон “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын дагуу 15 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан.<br>- Ажилд томилогдсон албан хаагчдыг ERP системд бүртгэх, eDoc-той холбох, албан хаагчдын албан тушаал болон хүний нөөцийн удирдлагын бүртгэлийн өөрчлөлт, нэгжийн бүтэц, орон тооны өөрчлөлт, шийдвэрийн бүртгэл, эрхийн тохиргоо зэрэг шаардлагатай бүх тохиргоог систем дээр тухай бүр хийж ажиллав.<br>- “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын дагуу албан хаагчдын 2025 оны ээлжийн амралтын болон орлон ажиллах хуваарийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- Албан хаагчдын хувийн хэргийн бүрдэлд тогтмол баяжилт хийж, шинээр томилогдсон албан хаагчдад хувийн хэрэг нээж, ажилдаа ирж очих үеийн маршрут болон холбогдох тушаал шийдвэр, баримтын нөхөн бүрдүүлэлтийг хийв. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 40 | Арга хэмжээ 2.6.5<br>Хяналтын улсын байцаагчийн эрх олгуулах, цуцлуулах саналыг холбогдох Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, шийдвэрлүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Хяналтын улсын байцаагчийн эрх олгуулах 12 хүсэлтийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрчим хүчний яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт тус тус хүргүүлж, нийт 7 байцаагчийн эрхийг олгосон. Мөн улсын байцаагчийн эрх цуцлуулах 3 хүсэлтийг Зам, тээврийн яам болон Эрчим хүчний яаманд хүргүүлж, цуцлуулсан. | 100% |
| 41 | Арга хэмжээ 2.6.6<br>Байгууллагын албан хаагчдад ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг солилцох, танин мэдэхүйн ач холбогдол бүхий “Мэдээллийн цаг” арга хэмжээг тогтсон хуваарийн дагуу зохион байгуулах | - | Сургалт, арга хэмжээний тоо | 5 | 30 | Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалаар баталсан хуваарийн дагуу байгууллагын “Мэдээллийн цаг” арга хэмжээний хүрээнд нийт 23 сургалт зохион байгуулж, албан хаагчдыг хамруулсан. Сургалтын сэдвүүд:<br>- Хадгаламжийн нэгж бүрдүүлэлт буюу цаасан суурьт архивын баримтыг үдэж хавтаслах заавар;<br>- Баримт бичгийн стандарт, бүрдлүүдэд тавигдах үндсэн шаардлага;<br>- Ногоон барилгын тодорхойлолт, үнэлгээний системүүд, онцлох жишээнүүд;<br>- Албан хэрэг хөтлөлтийн журам;<br>- Нарны сэргээгдэх эрчим хүчний бага чадлын тархмал эх үүсвэр;<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зарим асуудал<br>- Хиймэл оюун ухааны тухай ойлголт;<br>- Ажлын байрны стрессийг удирдах нь;<br>- Газрын харилцаа;<br>- Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй 14 мега төслүүдийн танилцуулга;<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зарим асуудал; | 90% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | - Санхүүгийн зохицуулалт, зээлийн ойлголт;<br>- Хяналт шалгалтын эрх зүйн орчин ба сайжруулах хэрэгцээ, шаардлага;<br>- Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг;<br>- Ажлын байрны эерэг харилцаа;<br>- Гэр хорооллыг шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэхтэй холбоотой судалгааны ажил. | |
| 42 | Арга хэмжээ 2.6.7<br>Байгууллагын дэргэдэх зөвлөлүүдийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх, тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагын дэргэдэх 10 зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Зөвлөлүүдийн бүрэлдэхүүнтэй 2025 оны 5 дугаар сард уулзалт зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар мэдээлэл солилцон, үйл ажиллагаагаа эрчимжүүлэх талаар чиглэл өгсөн. Зөвлөлүүдийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 08 дугаар сарын 27-ны өдөр болон 10 дугаар сарын 03-ны өдөр тус тус 2 удаа нэгтгэж, газрын даргад танилцуулсан.<br>Зөвлөлүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлыг товч дурдвал:<br>➢ Залуучуудын зөвлөл: Байгууллагын албан хаагчдын төрсөн өдрийг тэмдэглэх “Birthday Calendar”-ийг боловсруулж, мэндчилгээ дэвшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.<br>➢ Эцэг эхийн зөвлөл: Ажилтнуудын хүүхдийн судалгаа гарган, Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан гар зургийн уралдаан болон хүүхдэд | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | зориулсан өдөрлөг зохион байгуулж, хүүхэд бүрт бэлэг гардуулсан.<br>➢ Биеийн тамир спорт хамтлаг: "Тэрбум мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр IGM олон улсын цэцэрлэгт хүрээлэнд 15 агч мод, 5 монос тарьсан. "Нийслэлийн өвлийн спортын наадам", "Улаанбаатар марафон 2025" зэрэг арга хэмжээнд ажилтнуудын оролцоог хангаж, байгууллагын аварга шалгаруулах 5 төрөлт спортын тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан.<br>➢ Хүний эрх, жендерийн зөвлөл: Байгууллагын хэмжээнд "Хүний үнэ цэнэ, шударга ирээдүй" хоёр сарын аяныг зохион байгуулж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын постер болон "Хүний эрх ба жендер" сэдэвт видео танилцуулгыг байгууллагын мэдээллийн самбар болон дотоод группт байршуулан сурталчилан ажиллав. Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах референт Э.Мөнхзулыг урьж албан хаагчдад "Хүний эрх ба Жендер" сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж 45 албан хаагчийг хамруулав.<br>➢ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл: "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" сэдэвт дотоод сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, нийт 27 ажилтныг хамруулан аюулгүй | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | ажиллагаа, эрүүл ахуйн үндсэн зарчим болон хэрэгжүүлэх шаардлагатай асуудлуудын талаар танилцуулж, хэлэлцүүлэв. Шинээр томилогдсон албан хаагчдад ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод сургалтыг зохион байгуулсан. Мөн байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулж, хянуулахаар Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгийн шуурхай удирдлагын хэлтэст хүргүүлсэн. | |
| 43 | Арга хэмжээ 2.6.8<br>2025 онд идэвх санаачлагатай ажиллласан зөвлөл, хэлтэс, албан хаагчдыг шалгаруулах, шагнаж урамшуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагын хэмжээнд нийт 18 албан хаагч төрийн болон салбарын, нийслэлийн шагналаар шагнуулав. Үүнд:<br>➢ Төрийн дээд шагнал Алтан гадас одон 1, Хөдөлмөрийн хүндэт медаль 5 албан хаагч;<br>➢ ХББОСЯ-ны Салбарын Тэргүүний ажилтан 1, Жуух бичгээр 3 албан хаагч;<br>➢ Нийслэлийн Тэргүүний ажилтан 5, Жуух бичиг 8 албан хаагч;<br>➢ НИТХ-ын Хүндэт өргөмжлөлөөр 1 албан хаагч. | 100% |
| **Зорилт 2.7. Байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналт шалгалт хийж, эрсдэлийн удирдлагаар хангана.** | | | | | | | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 44 | Арга хэмжээ 2.7.1 Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шинжилгээ, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангуулах | - | Төлөвлөгөөний хэрэгжилт | - | 100 | Байгууллагын үйл ажиллагаанд учирч болохуйц эрсдэл, хүчин зүйлсийг тодорхойлж авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын дэргэдэх “Эрсдэлийн удирдлагын баг”-ийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан.<br>Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-ын дагуу байгууллагын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, боловсруулж батлуулж, биелэлтийг хангаж ажилласан. Эрсдэлийн төлөвшлийн түвшнийг үнэлж, үнэлгээний тайланг танилцуулсан. “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг боловсруулж байна. Мөн тус байгууллагаас ISO 31000 “Эрсдэлийн менежментийн тогтолцоо” стандартын “Дотоод аудитор”-ын бэлтгэх сургалтад 2 албан хаагчийг хамруулж, дотоод аудиторын эрх авсан. | 100% |
| 45 | Арга хэмжээ 2.7.2 Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, болон хэлтсүүдийн дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулан зөвлөмж хүргүүлэх | - | Дотоод хяналт шалгалт зохион байгуулсан тоо | 2 | 2 | Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, болон хэлтсүүдийн дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд 2025 онд 8 удаа дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдох дүгнэлт, зөвлөмж хүргүүлэв. Үүнд:<br>➢ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | түүвэрчилсэн байдлаар хяналт шалгалт хийж, нийт 108 баримт бичигт хяналт шалгалт хийж, 11 зөрчил илрүүлж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br>➢ Байгууллагын 4 албан хаагчийн ажлын байранд зураг авалт хийж, санал дүгнэлтийг байгууллагын удирдлагуудын хуралд танилцуулсан.<br>➢ Авлигатай тэмцэх газар, Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийн дагуу дотоод хяналт шалгалт зохион байгуулж, 2 албан хаагчид холбогдох зөрчлийн хүрээнд захиргааны арга хэмжээ авч, 1 албан хаагчид сануулах арга хэмжээг авч, 1 асуудалд холбогдуулан хариу тайлбар хүргүүлсэн.<br>➢ Газрын даргын 2025 оны “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/53 дугаар тушаалын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулж, үр дүнг газрын шуурхай хуралд танилцуулж, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэст зөвлөмж, авах арга хэмжээний санал хүргүүлэв.<br>➢ Газрын даргын баталсан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай” 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн удирдамжийн дагуу 6 хэлтсийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | албан хаагчдыг хамруулан, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт хууль, дотоод журмын дагуу хийгдэж байгаа эсэхэд 5 чиглэл, 12 шалгуур үзүүлэлтээр хяналт хийж, илэрсэн зөрчил, сайжруулах шаардлагатай асуудалд зөвлөмж хүргүүлсэн<br>➢ Газрын даргын баталсан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай” удирдамжийн дагуу Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн үйл ажиллагаа, төрийн хяналт шалгалт, хууль эрх зүйн хэрэгжилтийн байдалд 9 чиглэл, 33 шалгуур үзүүлэлтээр, Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн үйл ажиллагаа, төрийн хяналт шалгалт, хууль эрх зүйн хэрэгжилтийн байдалд 5 чиглэл, 10 шалгуур үзүүлэлтээр тус тус дотоод хяналт шалгалт зохион байгуулж, санал, зөвлөмж хүргүүлсэн. | |
| 46 | Арга хэмжээ 2.7.3<br>Улсын /ахлах/ байцаагчдын бүрэн эрхийн хүрээнд хийгдсэн хяналт шалгалт, эрх зүйн баримт бичигт хяналт тавих | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Газрын даргын баталсан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай” 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн удирдамжийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 10-наас 10 дугаар сарын 10-ны хооронд Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаа, хууль эрх зүйн хэрэгжилтийн байдалд 9 чиглэл, 33 шалгуур үзүүлэлтээр дотоод хяналт шалгалт зохион байгуулав. Шалгалтыг улсын /ахлах/ байцаагчдын бүрэн эрхийн хүрээнд хийгдсэн хяналт шалгалт, эрх зүйн баримт бичигт хяналт тавьж, шалгалтын дүнгийн дагуу санал, зөвлөмж хүргүүлж ажилласан. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Дотоод хяналт шалгалтаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, шийдвэрлэх явцад зөрчил гаргасан, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлээгүй албан тушаалтнуудын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:<br>- Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу хяналтын шар хуудас 40, улаан хуудас 4-ийг нийт давхардсан тоогоор 44 албан хаагчдад олгож, арга хэмжээ тооцсон.<br>- Дээд шатны байгууллага болон Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 3 удаагийн дүгнэлтийн дагуу 2 алба хаагчид захиргааны арга хэмжээ тус тооцож, мөн нийслэлийн Прокурорын газраас ирүүлсэн 4 удаагийн зөрчлийн шинжтэй мэдээллийн дагуу 2 албан хаагчид сануулах арга хэмжээ тооцож, дахин зөрчил гаргахгүй байх талаар заавар, зөвлөмжөөр ханган ажиллав. | |
| **Зорилт 2.8. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, Засгийн газрын сайдуудтай хийх гэрээ, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, газрын даргын үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн тайлагнах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.** | | | | | | | |
| 47 | Арга хэмжээ 2.8.1<br>Байгууллагын үндсэн чиг үүрэгт холбогдолтой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг нэгтгэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | 2025 оны байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбогдох нийт 30 тогтоол шийдвэрийн 62 заалтыг хяналтад авч ажилласан байна. Хяналтад авсан заалтын хэрэгжилтийг сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тогтоосон хугацаанд нь тайлагнаж, нийт 11 удаагийн тайлан илгээсэн байна. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 48 | Арга хэмжээ 2.8.2<br>Улс, нийслэлийг хөгжүүлэх богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлтийг хугацаанд нь тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Улс, нийслэлийг хөгжүүлэх богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан газрын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний биелэлтийг улирал тутамд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж тайлагнасан. Үүнд:<br>1. “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд байгууллагын хариуцах 2 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэж, 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.<br>2. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан 1 арга хэмжээний 2025 оны хагас жилийн биелэлтийг 06 дугаар сарын 02-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж, хугацаанд нь тайлагнасан.<br>3. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийг өссөн дүнгээр нэгтгэж, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлтийн хамт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/612 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.<br>4. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2025 оны наймдугаар сарын байдлаар нэгтгэн, нотлох | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | баримтын хамт 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр 01/768 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.<br>5. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2025 оны хэрэгжилтийг 2025 оны 12 дугар сарын 01-ний өдрийн 01/1192 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>6. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/1193 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.<br>7. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2025 оны хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/1194 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. | |
| 49 | Арга хэмжээ 2.8.3<br>Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан хамтран ажиллах гэрээний газрын чиг үүрэгт | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Монгол Улсын Засгийн газрын гишүүд болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан хамтран ажиллах дараах 6 сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд байгууллагын эрхлэх | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | хамаарах зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, хугацаанд нь тайлагнах | | | | | асуудал, чиг үүрэгтэй уялдуулан нийт 19 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/17 дугаар тушаалаар батлуулсан. Үүнд:<br>1. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга- 2 арга хэмжээ;<br>2. Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хороо- 2 арга хэмжээ;<br>3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд- 1 арга хэмжээ;<br>4. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд- 6 арга хэмжээ;<br>5. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд- 3 арга хэмжээ;<br>6. Эрчим хүчний сайд- 5 арга хэмжээ.<br>Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар тайлагнаж ажиллав. Үүнд:<br>➢ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай байгуулсан гэрээний эхний хагас жилийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр НЗДТГ-т цахимаар хүргүүлсэн.<br>➢ Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргатай байгуулсан гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/535 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.<br>➢ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | өдрийн 01/1163 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>➢ Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1164 дугаартай НЗДТГ-ын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. | |
| 50 | Арга хэмжээ 2.8.4<br>Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын биелэлтийг хангуулах, шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, тухай бүр заагдсан хугацаанд тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэлийн Засаг даргын 2025 онд баталсан захирамж, албан даалгавар, шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хүлээн авч, хэрэгжилтийг ханган ажиллаж, тухай бүр заагдсан хугацаанд тайлагнаж ажилласан.<br>- Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан болон бусад захирамжуудын хэрэгжилтийг заагдсан хугацаанд тайлагнаж, нийт 9 удаагийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.<br>- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 22 удаа зохион байгуулагдаж, газрын чиг үүрэгт хамаарах нийт 81 үүрэг даалгавар (үндсэн хэрэгжүүлэх 28) өгөгдөн, 93,1 хувьтай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тайлагнаж ажилласан. Мөн 2025 оны 1 дүгээр сараас хойш Нийслэлийн шуурхай хуралдаанаар өгөгдсөн нийт 21 үүрэг | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | даалгаврын биелэлтийг нэгтгэн, 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр өдөр, Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс 2024 онд өгсөн 1 үүрэг даалгавар, 2025 онд өгсөн 41, нийт 42 үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн ДХШХ-ийн даргаар баталгаажуулж, 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тус тус тайлагнасан.<br>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр дүүрэг, хороодын Засаг дарга нартай хийсэн ээлжит 03 дахь уулзалтаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 01/1037 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан. | |
| 51 | Арга хэмжээ 2.8.5<br>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1024 дүгээр захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс хариуцсан чиг үүргийн дагуу индексийн үзүүлэлтийг үйл ажиллагаандаа уялдуулж, сайжруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Хотын хөгжлийн индексийн 86 үзүүлэлтээс байгууллагын чиг үүрэгтэй уялдах 6 үзүүлэлтийг тодорхойлон, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгасан. | 90% |
| 52 | Арга хэмжээ 2.8.6<br>Газрын үндсэн чиг үүргийн хүрээнд нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар асуудал | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хуралдаанаар “Барилга, дэд | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | танилцуулж, хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | | | | | бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр”-ийн төслийг танилцуулсан. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01, 04 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн 4 үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. Мөн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн 4 үүрэг даалгавар, 07 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн 5 үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж, тайлагнасан. | |
| 53 | Арга хэмжээ 2.8.7<br>Хяналт шалгалтын газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөөг тухай бүр батлуулах, зохион байгуулах, үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах | - | Хэлэлцэх асуудал, өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, хувь | 100 | 100 | Хяналт шалгалтын газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж, 18 асуудал хэлэлцэж, нийт 42 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Үүрэг даалгаврын хэрэгжилт 92.3 хувьтай байна. | 90% |
| 54 | Арга хэмжээ 2.8.8<br>Хяналт шалгалтын газрын даргын шуурхай хуралдааныг зохион байгуулах, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд тайлагнах | - | Хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, хувь | 100 | 100 | Хяналт шалгалтын газрын даргын шуурхай хуралдааныг 22 удаа зохион байгуулж, нийт 270 үүрэг даалгавар өгсөн бөгөөд үүрэг даалгаврын биелэлтийн дундаж нь 91.4 хувьтай байна. | 90% |
| **Зорилт 2.9. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, стандартыг мөрдлөг болгоно.** | | | | | | | |
| 55 | Арга хэмжээ 2.9.1<br>2024 онд байгууллагын хэмжээнд хөтлөгдсөн бүх бичиг баримтуудыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нөхөн бүрдүүлэлт хийх, данс бүртгэл үйлдэх, Баримт | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагын хэмжээнд 2024 онд үүсч хөтлөгдсөн баримтуудыг батлагдсан хуваарийн дагуу хэлтсүүдээс цаасан суурьтай 360 боть, цахим 6 баримтыг шалган үдэж хавтаслан хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээн авч данс бүртгэл | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцэн батлах, тайлагнах | | | | | үйлдэх ажлыг хуваарийн дагуу хийж дуусгасан. Үүнд: Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 онд хөтлөгдсөн цаасан суурьтай **360** боть, цахим **6** баримтыг хүлээн авч, хадгаламжийн нэгж үүсгэсэн байна.<br>- Байнга хадгалах 272 боть;<br>- Байгууллагад хадгалах 2 боть;<br>- Түр хадгалах 76 боть;<br>- 70 жил хадгалах 10 боть.<br>2024 онд үүссэн захирамжлалын цахим баримт буюу ХШГ-ын А/01-А/87, Б/01-Б/126, ХСХГ-ын А/01-А/24, Б/01-Б/23 тушаалуудыг Archive EDoc программд шивж бүртгэн харьяалах төрийн архивын мэргэжилтэнд хянуулж, 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр төрийн архивт шилжүүлэн акт үйлдсэн. | |
| 56 | Арга хэмжээ 2.9.2<br>2025 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулж, Нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | 2025 онд хөтлөгдөх хэтлэх хэргийн нэрийн жагсаалтад хэлтэс нэгжүүдээс санал авч боловсруулж, байгууллагын БНШК-ын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар хурлаар хянан хэлэлцэж, газрын даргаар батлуулсан. | 100% |
| 57 | Арга хэмжээ 2.9.3<br>Архивын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулах, төлөвлөгөө гаргаж зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, төлөвлөгөөг газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/78 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нийт 17 албан хаагч оролцов. Бэлтгэл ажлын хүрээнд архивын сангийн баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор архивын өрөөний камер, галын булан, | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хөдөлмөр хамгааллын болон дохиолол хамгаалалтын хэрэгсэл зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлэв. Нийслэлийн Архивын газрын дарга бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Зөрчил арилгуулах тухай” 09/04 дүгээр албан шаардлагын хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын архивын сангийн баримтын тооллого зохион байгуулах комисс байгуулж, 2020-2023 оны баримтад тооллого зохион байгуулсан. Албан хаагчдад баримт бичиг боловсруулах арга зүйг сайжруулах хүрээнд ynam 16 төрлийн гарын авлага боловсруулан тараасан. Улсын үзлэгийн 3 үндсэн үзүүлэлт, 87 шалгуур үзүүлэлт тус бүрээр 2020–2024 оны баримтыг шүүж, цаасан болон цахим баримтыг бүрдүүлэв. Нийслэлийн Засаг даргын А/1220 дугаар захирамжаар батлагдсан хуваарийн дагуу тус газарт 2025 оны 10 дугаар сарын 15–16-ны өдрүүдэд зохион байгуулаглаж, нэгдсэн дүн, зөвлөмжийг танилцуулсан. | |
| 58 | Арга хэмжээ 2.9.4<br>Байгууллагын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулж, зөрчил үүсгэхгүй ажиллах, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлэх | - | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хувь | - | 100 | **1. Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:** Байгууллагын хэмжээнд 2025 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар байгууллагын хэмжээнд нийт 4287 албан бичиг ирснээс 162 буюу 3,8 хувь нь судлагдаж байгаа, 4125 буюу 96,2 хувь нь хугацаанд нь шийдвэрлэгдсэн байна. Мөн байгууллагаас бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд рүү нийт 1195 албан бичиг илгээснээс 122 нь хариутай, 1073 нь хариугүй бичиг байна. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 2918 өргөдөл, гомдол хүлээн авснаас 100 буюу 3.43 хувь нь судлагдаж байгаа, 2818 буюу 96,57 хувь нь хугацаанд нь шийдвэрлэгдсэн байна. Өргөдөл, гомдлыг ангилбал:<br>➢ Талархал – 10 (0.12%)<br>➢ Санал – 12 (0.14%)<br>➢ Хүсэлт – 975 (11.45%)<br>➢ Гомдол – 1892 (22.22%)<br>➢ Мэдэгдэл – 10 (0.12%)<br>➢ Зөрчил – 5 (0.38%)<br>**2. Шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах чиглэлээр:** Байгууллагын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, гарч буй зөрчлийн талаар газрын дарга, нэгжийн удирдлагуудад тогтмол танилцуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад нийт 183 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс:<br>➢ Хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн – 10<br>➢ Явцын тэмдэглэл хөтлөөгүй – 68<br>➢ Өдөрт нь багтаан шилжүүлээгүй – 48<br>➢ Өдөрт нь багтаан хүлээн аваагүй – 60<br>➢ Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй – 7<br>Шийдвэрлэлтийн явцад удаа дараа зөрчил гаргасан нийт 18 албан хаагчид байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу “Хяналтын шар хуудас” олгож, сануулах арга хэмжээ авч, хариуцлага тооцсон. Мөн 2 албан хаагчид | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | сахилгын арга хэмжээг авсан. Иргэд, аж ахуйн нэгжийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд чанартай, үндэслэлтэй хариу өгөх, явцын тэмдэглэл хөтлөх, шилжүүлэлтийг өдөрт нь хийх зэрэгт хяналт тавьж, хариуцсан нэгж, албан хаагчдад санамж, мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.<br>Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн иргэдийн өргөдөл, гомдол, уулзалтын шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн, 7 төвийн төрийн үйлчилгээний оператор ажилтнууд, өргөдөл, гомдлын хяналт хариуцсан ажилтнууд, лавлагаа мэдээлэл хариуцсан оператор ажилтнууд зэрэг 30 гаруй бүрэлдэхүүнтэй цахим уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтын хүрээнд байгууллагын чиг үүрэгт хамааралгүй өргөдөл гомдол шилжүүлж, өргөдөл, гомдлын тоог хиймэлээр өсгөдөг асуудлын талаар танилцуулж, харилцан мэдээлэл солилцсон. Үүний дагуу тус байгууллагаас 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 05/1083 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн үйлчилгээний төвд барилга, дэд бүтцийн салбарын чиг үүрэг, өргөдөл, гомдлын судалгаа, чиг үүрэгт хамааралгүй асуудлын судалгааг гарган хүргүүлсэн.<br>**3. Тайлан, мэдээ:** Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг долоо хоног, улирал тутамд тогтмол хүргүүлсэн. Үүнд: 36 удаа долоо хоногийн тайлан, 3 | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | удаа улирлын тайланг хугацаанд нь хүргүүлэв. | |
| 59 | Арга хэмжээ 2.9.5<br>Албан хэрэг хөтлөлтийг кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм, журмыг мөрдөж ажиллах, албан хаагчдыг сургалт, арга зүйгээр хангах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | - Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд газрын даргын тушаал болон албан бичгийг хос бичгээр хөтөлж хэвшсэн ба 1150 албан бичиг, 120 тушаалыг монгол бичгээр хөрвүүлж, хэвлэмэл хуудаст буулгав.<br>- Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/377 дугаарт албан бичгээр иргүүлсэн “Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх тухай зөвлөмж”-ийн хүрээнд 2025 оны 1 дүгээр улирлын тайланг 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/253 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.<br>Архив, албан хэрэг хөтлөлт, компьютер, үндэсний монгол бичгийн чадварыг дээшлүүлэх хүрээнд дараах сургалтуудад албан хаагчдыг хамруулав. Үүнд:<br>- Албан хаагчдын үндэсний монгол бичгийн ур чадварыг сайжруулах зорилгоор нийт албан хаагчдаас монгол бичгийн мэдлэг, хэрэгцээ шаардлагын талаар судалгааг авсан. Үүнтэй холбогдуулан 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын 4 албан хаагчид монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.<br>- Архивчдын сургалт, хөгжил арга зүйн төвтэй хамтран “Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр байгууллагын албан хаагчдыг хамруулсан. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулсан 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Цахим монгол бичгийн сургалтад 6 албан хаагч хамрагдсан.<br>- Нийслэлийн Архивын газраас 2025 оны 02 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулсан архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтад байгууллагын Архивын ажилтан хамрагдсан. | |
| **Зорилт 2.10. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.** | | | | | | | |
| 60 | Арга хэмжээ 2.10.1<br>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг бүрэн хангах | - | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь | 100 | 100 | Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгууллагын “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, нийт 3 зорилт, 15 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/575 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв. Түүнчлэн Хяналт шалгалтын газрын даргын “Эрх зүйн актад тавих хяналтыг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” чиглэлийг батлан, 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр холбогдох хэлтсүүдэд хүргүүлэв. | 100% |
| 61 | Арга хэмжээ 2.10.2 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулна | | | | | зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд дараах 2 удаагийн сургалт болон сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Үүнд:<br>➢ Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан “Нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэрэг”-т оногдуулах ялын хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг” сэдвээр нийт албан хаагчдад мэдээллийн цаг зохион байгуулсан.<br>➢ Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр “Авлигаас урьдчилан сэргийлэх нь: Анхаарах асуудал” сэдвээр нийт албан хаагчдад мэдээллийн цаг зохион байгуулсан.<br>➢ Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 2 ТВ шторк, 5 зурагт хуудас, 7 мэдээ, мэдээллийг лэд дэлгэц, байгууллагын мэдээллийн самбар, вэб сайт, пэйж хуудас зэрэгт байршуулан иргэд, олон нийтэд тухай бүр мэдээллийг хүргэж ажиллав.<br>➢ Авлигын эсрэг “НЭГДЬЕ” аяныг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, үйл ажиллагааны талаарх мэдээллийг вэб сайт, Иргэдийн төлөөлөгчдийн систем, пэйж хуудас зэрэг сувгаар иргэд, олон нийтэд сурталчлан ажиллав. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | ➢ Байгууллагын онцлогт тохирсон дараах хэвлэмэл хуудас, сурталчилгааны материалыг мэдээллийн самбар, вэб сайт, пэйж хуудас зэрэгт байршуулан иргэд, олон нийтэд авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тогтмол хүргэж ажиллав. “Бод, нягтал, тэгээд татгалз” уриатай зурагт хуудас, сурталчилгааны материал - 50 ширхэг, “Шударга ёс, хөгжил дэвшилд хүргэх 110” мэдээллийн хэвлэмэл хуудас - 50 ширхгийг тус тус тараасан байна. | |
| 62 | Арга хэмжээ 2.10.3 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын баталсан 2025 оны “Авлигын эсрэг төлөвлөгөө”-ний дагуу авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, барилга, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Авлигатай тэмцэх газар зэрэгтэй хамтран “Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоо” сэдэвт хэлэлцүүлгийг 04 сарын 16-ны өдөр зохион байгуулж, 200 гаруй төлөөлөл оролцсон. Хэлэлцүүлгийн санал, дүгнэлтэд үндэслэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулах, барилгын салбарт оролцогчдын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газар, улсын комиссын | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | бүрэлдэхүүнд ажиллаж буй бүрэлдэхүүн байгууллагууд, барилга угсралтын компанийн төлөөллүүдийг оролцуулан шинэчлэн найруулсан Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм батлах тухай” 212 дугаар тогтоолын өөрчлөлт оруулах хүрээнд тогтоолын төсөл, дүрмийг танилцуулах, санал авах уулзалтыг 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| 63 | Арга хэмжээ 2.10.4 ХАСХОМ (Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг)-ийг мэдүүлэх эрх бүхий албан хаагчдаас шинэчлэн болон шинээр авах, хяналт тавих | - | Албан хаагчдын тоо | 72 | 55 | ХАСХОМ (Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг)-ийг 48 албан хаагчаас хуульд заасан хугацаанд хүлээн авч, хянан баталгаажуулсан. | 100% |
| 64 | Арга хэмжээ 2.10.5 Шинээр нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн албан хаагчдаас ХАСУМ (Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг)-ийг хүлээн авч баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Шинээр томилогдох, албан үүрэг хавсран гүйцэтгэх, болон шилжин ажиллахаар нэр дэвшсэн нийт 24 албан хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хүлээн авч баталгаажуулан, холбогдох материалыг бүрдүүлэн Авлигатай тэмцэх газрын Дүн шинжилгээ хяналт, шалгалтын хэлтсээр хянуулав. | 100% |
| **Зорилт 2.11. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, хэм хэмжээг мөрдлөг болгох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 65 | Арга хэмжээ 2.11.1 “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030 он)”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хорооны даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн шийдвэрээр 2 зорилтын 8 арга хэмжээг төлөвлөж, тайлант хугацаанд хэрэгжилтийг ханган ажиллав. Үүнд: | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | - Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулав.<br>- Байгууллагын албан хаагчдын ёс зүй, зан харилцааны талаар санал асуулга явуулж, шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан хаагчийг тодруулж, газрын удирдлагад 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр танилцуулав.<br>- Ёс зүйн дэд хорооны 2024 оны тайланг нэгтгэж, 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02/88 дугаар албан бичгээр Ёс зүйн хороонд хүргүүлэв.<br>- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 3 гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, “Ёс зүйн дэд хороо”-ны 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01 дугаартай дүгнэлтийг албажуулж, газрын удирдлагад хүргүүлж ажиллав.<br>- Нийслэлийн Хүний нөөцийн сургалтын төвийн багш Ш. Жаргалсайхан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулав.<br>- Байгууллагын Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөнд тусгагдсан “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сарын аян”-ы хүрээнд зохион байгуулагдах “Стресс ба ажлын байран дахь харилцаа”, “Удирдах ажилтны ёс зүйт манлайлал” сэдэвт сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан.<br>➢ Сэтгэлзүйч багш Б.Баярмаатай хамтран албан хаагчдын сэтгэлзүйн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | эрүүл мэндийг дэмжих зорилгоор ганцаарчилсан уулзалт, зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулж, нийт 6 албан хаагчийг хамруууллаа.<br>➢ Ёс зүйн дэд хорооноос санаачлан зохион байгуулж буй "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх аян"-ы хүрээнд нийт албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, урам зориг өгөх зорилгоор “Талархлын самбар”-ыг байршууллаа. Мөн тус аяны хүрээнд шилжин явах дарцгыг хэлтсүүдээр аялуулж, үлгэр жишээ хэлтсийг шалгаруулахаар ажиллаж байна. | |
| 66 | Арга хэмжээ 2.11.2<br>Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, зааврaар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хэм хэмжээ”-г хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын албан хаагчдад зориулсан ёс зүйн сургалт, дотоод журмын шинэчлэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллалаа. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн гишүүнийг нөхөн томилох зорилгоор нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулж, хамгийн олон санал авсан 2 албан хаагчийг “Ёс зүйн дэд хороо”-ны бүрэлдэхүүнд томилов. | 100% |
| 67 | Арга хэмжээ 2.11.3 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Тус газрын Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Төрийн албан | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн шаардлага, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хэм хэмжээ”-г мөрдлөг болгох | | | | | хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг” сэдвээр нийт албан хаагчдад мэдээллийн цаг зохион байгуулав. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн шаардлага, ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах зорилгоор 3 төрлийн танилцуулга, шторк, зөвлөмжийг боловсруулан байгууллагын албан хаагчдад хүргүүлсэн. | |
| 68 | Арга хэмжээ 2.11.4<br>Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 3 гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, “Ёс зүйн дэд хороо”-ны 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01 дугаартай дүгнэлтийг албажуулж, цахим хуудас, "Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт" цахим системд мэдээлж ажиллав. | 100% |
| **Зорилт 2.12. Жендэрийн тэгш байдлыг хангах хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулна.** | | | | | | | |
| 69 | Арга хэмжээ 2.12.1<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх | - | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, жендерийн эрх тэгш байдлыг хангах, албан хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хүний эрх, жендерийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулж, дараах ажлыг хэрэгжүүлэв. Үүнд:<br>- НЗДТГ-аас ирүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг гарган 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/888 дугаар албан бичгээр хариуцсан мэргэжилтэнд цахимаар хүргүүлэв.<br>- Хүний эрхийн Үндэсний комиссын ахлах референт Э.Мөнхзулыг урьж “Хүний эрх | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | ба жендер" сэдэвт сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, 45 албан хаагчийг хамруулав.<br>- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу тайланг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/1147 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлэв.<br>- Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдын хүний эрх, эрх чөлөө, жендерийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хандлага төлөвшүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангав. | |
| 70 | Арга хэмжээ 2.12.2<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр худалдан авах ажлыг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, сурталчлан таниулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2025 оны 12 дугаар сард байгууллагын хэмжээнд өдөрлөг арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн. | 90% |
| 71 | Арга хэмжээ 2.12.3<br>Байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангаж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагын албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор принтерийн засвар, хор цэнэглэх, авто засварын зардалд нийт 21,044,280 төгрөг, хэвлэмэл хуудас хэвлэлд 6,636,330 төгрөг, сургалтын өрөөнд тавилга болон албан хаагчдын хэрэгцээнд шаардлагатай багаж, техник хэрэгсэл худалдан авахад 191,039,10 төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авахад 40,587,500 төгрөгийн гүйлгээ хийж, эдгээрт холбогдох анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллав. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 2.13. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 72 | Арга хэмжээ 2.13.1<br>Барилга, дэд бүтцийн салбарын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, салбарын оролцогчдыг соён гэгээрүүлэх чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн сургалт зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Барилга, дэд бүтцийн салбарын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:<br>1. Барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, орчны аюулгүй байдлыг хангуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн 9 дүүргийн аж ахуйн нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодын 610 төлөөлөлд сургалт зохион байгуулсан.<br>2. Томоохон зах худалдааны төвүүдийн 64 менежер, худалдааны зөвлөхүүдэд ахуйн хэрэглээний шингэрүүлсэн шатдаг хийн худалдаа, зохистой хэрэглээ, холбогдох хууль, эрх зүйн орчны талаарх мэдлэг олгох сургалт зохион байгуулсан.<br>3. 220 граммын ахуйн хэрэглээний шингэрүүлсэн шатдаг хийн худалдаа, зохистой хэрэглээ, эрх зүйн орчны талаар 5 ААН-ийн 73 сүлжээ дэлгүүрт хийн хэрэглээтэй холбоотой брошюр, улсын байцаагчийн зөвлөмж тараав.<br>4. Даралтат савыг ашиглахтай холбоотой норм, дүрмийн хэрэгжилт, өндөр даралтат хийн ойлголт, хүчилтөрөгчийн шахсан хийн баллоны ашиглалт аюулгүй ажиллагаа сэдвээр Онцгой байдлын 21 аймгийн Онцгой байдлын газруудаас ирсэн 46 алба хаагчдад сургалт зохион байгуулав.<br>5. Нийслэлийн орон сууцны 1 давхарт хоол үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэд | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | болон орон сууцны СӨХ-үүдийн ажилтнуудад шингэрүүлсэн шатдаг хийн зохистой хэрэглээ, ашиглалт аюулгүй ажиллагаа сэдвээр нийт 610 иргэд, ААНБ-д сургалт зохион байгуулав.<br>6. Нийслэлийн 8 дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, хангамж үйлчилгээний ажилтнуудад зориулан “Баллонт тоног төхөөрөмж, 220 граммын шингэрүүлсэн шатдаг хийн аюулгүй ажиллагаа” сэдвээр 384 захирал, эрхлэгч, албан хаагчдад сургалт зохион байгуулж, гарын авлага, боршур тараав.<br>7. Юнигаз ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус компанийн автомашин хийгээр цэнэглэх станцын эрхлэгч, түгээгч борлуулагч нийт 150 албан хаагчдад Хийн хангамж БНбД 42-01-19, хийн аж ахуйн аюулгүй ажиллагаа, хийн аж ахуйн техник ашиглалтын дүрэм сэдвээр сургалт зохион байгуулав.<br>8. Дүнжингарав худалдааны төвд хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг 48 иргэн, аж ахуйн нэгжид сургалт зохион байгуулав.<br>9. Иргэд, ААН-үүдэд шингэрүүлсэн хийн хэрэглээний гарын авлага 500 ширхэг, аюулгүй ажиллагааны стикер 300 ширхгийг тараав. | |
| 73 | Арга хэмжээ 2.13.2<br>Төрийн хяналтыг шуурхай зохион байгуулах, баталгаажсан хяналтын үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | үзүүлэх хүрээнд багаж, техник хэрэгслээр улсын байцаагчдыг хангах | | | | | зорилгоор шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн нарийвчилсан жишиг үзүүлэлтийг боловсруулж, Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. 2024 онд худалдан авалт хийгдсэн багаж, тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлжүүлэн, Стандарт, хэмжилзүйн газраар баталгаажуулж, албан хаагч бүрт картжуулан олгосон. | |
| 74 | Арга хэмжээ 2.13.3<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор “Нийслэлийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулагдсан бөгөөд тус ажлын хэсэгт тус газрын дарга ахлагчаар томилогдон. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий 10 дэд ажлын хэсгийг байгуулж, эрх зүйн орчны болон барилга, дэд бүтцийн чиглэлээр судалгаа, шинжилгээг үе шаттайгаар хийж, саналыг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хүргүүлэв. | 100% |
| **Зорилт 2.14. Зорилтот жилийн хүрээнд барилга, дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд хяналт тавих, иргэдийн амьдрах орчныг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 75 | Арга хэмжээ 2.14.1<br>Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг чиг үүргийн хүрээнд хангуулах, тайлагнаж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/33 дугаар захирамж, Хяналт шалгалтын даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/23/09 дугаартай удирдамжийн дагуу агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | тооллого, хяналт шалгалтын ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 37 албан хаагч ажилласан. Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт 3-15кВт хүртэл хүчин чадалтай халаалтын зуух зуух ашиглагч нийт 420 айл өрх, нийслэлийн 7 дүүргийн нутаг дэвсгэрт 15-100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух ашиглагч нийт 456 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хяналт шалгалтад хамрагдсан. Шалгалтын танилцуулга, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Онцгой комисс, Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт тус тус 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/64 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв. | |
| **ГУРАВ. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Зорилт 3.1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулна. /Газрын дүрмийн- 4.4./** | | | | | | | |
| 76 | Арга хэмжээ 3.1.1<br>Барилга байгууламж, гадна цахилгаан хангамж, их засвар, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах хүсэлтийг судлах, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх | - | Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | Нийслэлийн хэмжээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулах хүсэлтийг төрийн үйлчилгээний нэгдсэн портал болох www.e-mongolia.mn, www.e-business.mn, www.edoc.ulaanbaatar.mn зэрэг цахим системүүдээр дамжуулан шаардлагатай баримт бичгийн бүрдлийн хамт хүлээн авч, иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн хүсэлтүүдийг ажлын 5-7 хоногийн хугацаанд судлан шийдвэрлэж байна. 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 1848 хүсэлт хүлээн авч, | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | судлан шийдвэрлэсэн бөгөөд систем тус бүрээр дараах байдлаар ангилав. Үүнд:<br>www.e-mongolia.mn - цахим системээр:<br>• Барилга байгууламж – 439<br>• Цахилгаан хангамж – 758<br>• Засвар, тохижилт – 16<br>www.e-business.mn - цахим системээр:<br>• Барилга байгууламж – 116<br>• Цахилгаан хангамж – 110<br>www.edoc.ulaanbaatar.mn Нийслэлийн дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр:<br>• Барилга байгууламж – 140<br>• Цахилгаан хангамж – 70<br>• Засвар, тохижилт – 199 | |
| 77 | Арга хэмжээ 3.1.2<br>Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийн дагуу барилгын ажлын гүйцэтгэлд урьдчилсан үзлэг хийх, бэлэн байдлыг хангуулах | - | Урьдчилсан үзлэг хийсэн барилгын тоо | 274 | 200 | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийн дагуу барилга байгууламж, түүний гадна талбайн тохижилт, засвар, тоноглолын ажлыг ашиглалтад оруулах бэлтгэл хангах хүрээнд нийт 340 барилгад урьдчилсан үзлэг хийж, ажлын гүйцэтгэлийг илтгэх хуудсаар баталгаажуулан газрын даргад танилцуулан комиссын хуваарьт тусгасан. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах-44, барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах-31 хуваарийн төслийг боловсруулан газрын даргаар батлуулсан. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 78 | Арга хэмжээ 3.1.3<br>Барилга байгууламжийг ашиглалтад комиссын үйл ажиллагааг хуваарийн дагуу зохион байгуулж, дүгнэлтийг баталгаажуулах | - | Комиссын үйл ажиллагааг зохион байгуулсан тоо | 880 | 500 | Монгол Улсын Засгийн засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/503 дугаар захирамжийн дагуу комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг хангасан нийт 897 барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт, хурлын тэмдэглэлийг баталгаажуулав. Үүнд:<br>➢ Барилга байгууламж - 324;<br>➢ Барилгын засвар, тохижилтын ажил - 100<br>➢ Гадна цахилгаан хангамжийн ажил - 473 | 100% |
| 79 | Арга хэмжээ 3.1.4<br>Ашиглалтад орсон барилга байгууламжийн орон зайн мэдээллийн санг баяжуулах | - | Мэдээллийн санд бүртгэсэн барилга байгууламжийн тоо | 870 | 500 | Орчны аюулгүй байдлын мэдээллийн сангийн “Барилга байгууламжийн дэд мэдээллийн сан”-д 6 төрөлт өгөгдлөөр оруулж, нийт 912 объектын дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэн баяжилт хийсэн. Үүнд:<br>1. Орон сууцны барилга - 170<br>2. Олон нийтийн барилга - 154<br>3. Цахилгаан хангамж - 473<br>4. Шугам, сүлжээ - 15<br>5. Их засвар, шинэчлэлт - 42<br>6. Тохижилт - 58 | 100% |
| 80 | Арга хэмжээ 3.1.5<br>Ашиглалтад орсон барилга байгууламжийн талаарх мэдээллийг нэгтгэж дээд шатны байгууллага болон газрын удирдлагыг мэдээллээр хангах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | - Тагнуулын ерөнхий газрын Нийслэл дэх газрын хүсэлтийн дагуу ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээлэл, комиссын хуралдааны шийдвэрийг 7 хоног бүр хүргүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд нийт 44 удаа цахим шуудангаар мэдээлэл илгээсэн.<br>- “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгавар “Шил” ажиллагааны | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс 2025 оны 03 дугаар сарын 30-ны хүртэлх хугацаанд ашиглалтад орсон нийт 595 барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт, холбогдох мэдээллийг нэгтгэн www.shilen.gov.mn-д байршуулахаар Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | |
| **Зорилт 3.2. Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын чиглэлээр эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ.** | | | | | | | |
| 81 | Арга хэмжээ 3.2.1<br>Барилга угсралт, хот төлөвлөлт, өргөх байгууламж, ус хангамж, ариутгах татуурга, барилгын материал, газар, геодези, зураг зүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 96 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | | Шалгалт хийсэн объектын тоо | 126 | 96 | Барилга угсралт, хот төлөвлөлт, өргөх байгууламж, ус хангамж, ариутгах татуурга, барилгын материалын чиглэлээр нийт **97** (100 хувь) объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийв. Үүнд:<br>1) **Барилгын техникийн хяналт:** 30 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн 20 хуулийн этгээдэд улсын /ахлах/ байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. Дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 6 хуулийн этгээдэд улсын байцаагчийн 24 заалт бүхий 6 албан шаардлага хүргүүлж, их эрсдэлтэй үнэлэгдсэн 4 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу 20.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, ЭБАТ-ын зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.<br>2) **Хот төлөвлөлтийн хяналт:** 15 ААНБ-д төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, их эрсдэлтэй үнэлэгдсэн 1 хуулийн этгээдэд 10.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3 хуулийн этгээдэд 12 заалт бүхий улсын ахлах байцаагчийн албан | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | шаардлага хүргүүлж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн 6 хуулийн этгээдэд улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлэв. Үйл ажиллагаа зогссон 5 хуулийн этгээдийг шилэн хяналтын системд бүртгэж ажиллав.<br>3) **Өргөх байгууламжийн хяналт:** 20 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, бага эрсдэлтэй гарсан 17 ААНБ-д улсын байцаагчийн зөвлөмж, дунд эрсдэлтэй гарсан 3 ААНБ-д улсын /ахлах/ байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэв.<br>4) **Барилгын материалын хяналт:** 22 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, их эрсдэлтэй гарсан "Талын төмөр буга" ХХК-д 5.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Дунд эрсдэлтэй гарсан 9 ААНБ-д улсын ахлах байцаагчийн 27 заалт бүхий хугацаатай албан шаардлага, бага эрсдэлтэй 8 ААНБ-д улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.<br>5) **Усан хангамж, ариутгах татуургын хяналт:** 10 ААНБ-д төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, дунд эрсдэлтэй гарсан 2 ААНБ-д улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага, бага эрсдэлтэй 7 ААНБ-д улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлэв. Мөн 1 ААНБ 2025 онд үйл ажиллагаа явуулаагүй талаар мэдэгдсэн. | |
| 82 | Арга хэмжээ 3.2.2<br>Дэд бүтцийн салбарт эрчим хүч /цахилгаан, дулаан/, авто тээвэр, авто зам, замын байгууламж, | | Шалгалт хийсэн объектын тоо | 71 | 82 | Эрчим хүч, газрын тос хийн хяналт, авто тээвэр, авто замын хяналтын чиглэлээр нийт **78** (95 хувь) объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийв. Үүнд: | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | харилцаа холбоо, газрын тос, хийн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 82 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | | | | | 1) **Эрчим хүчний хяналт (цахилгаан, дулаан):** Шинээр ашиглалтад орж буй барилгын гадна дулааны шугам сүлжээний зураг төсөл, угсралтын байдалд нийт 10 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийсэн. Үр дүнд нь 5 аж ахуйн нэгжид албан шаардлага, 1 зөрчлийн хэрэг нээн хэрэг бүртгэл явуулсан.<br>2) **Авто замын хяналт:** 10 аж ахуйн нэгж, байгууллагын авто зам, гүүрэн байгууламжийн барилгын ажил, зураг төсөл, холбогдох баримт бичигт хяналт шалгалт хийж, 12 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.<br>3) **Автотээврийн хяналт:** 20 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж, 151 зөрчлийг илрүүлж, 18 зөрчлийг газар дээр арилгуулан, 181 заалт бүхий 20 албан шаардлага гаргасан. Үр дүнгийн танилцуулгыг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, НЗДТГ болон дүүргүүдийн ЗДТГ-т албан бичиг хүргүүлсэн.<br>4) **Газрын тос, хийн хяналт:** 28 агуулахад хяналт шалгалт хийж, 160 заалт бүхий албан шаардлага гаргасан. 10 агуулахад торгууль ногдуулж, нийт 10,000,000 төгрөгийг бүрэн төлүүлсэн. Шалгалтын дүнг 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн.<br>5) **Харилцаа холбооны хяналт:** Эрх бүхий албан тушаалтан байхгүй тул төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 3.3. Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын чиглэлээр болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ.** | | | | | | | |
| 83 | Арга хэмжээ 3.3.1<br>Барилга, хот байгуулалтын салбарын хяналтын чиглэлээр 499 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | - | Объектын тоо | 367 | 499 | Барилгын салбарын 5 хяналтын чиглэлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад нийт 1412 объектыг хамруулав. Хяналт шалгалтын ажлаас дурдвал:<br>➢ Барилгын техникийн болон барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 50 иргэн, 87 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, нийт 40 зөрчил илрүүлэн 50 заалттай 13 албан шаардлага, 3 дүгнэлт, 701 заалттай 95 зөвлөмж хүргүүлж, 143.4 сая төгрөгийн торгууль ногдуулсан.<br>➢ Нийслэлийн 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 68 цэцэрлэг, 64 сургууль буюу нийт 132 объектод хяналт шалгалт хийж, 654 зөрчил, дутагдлыг илрүүлж, 132 зөвлөмж, 45 шаардах хуудас хүргүүлэв.<br>➢ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн шаардлага хангуулуулах зорилгоор нийт 610 иргэн, аж ахуйн нэгжид (орон сууц, олон нийтийн 450; сургууль, цэцэрлэг 160) хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.<br>➢ Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч 7 хуулийн этгээдэд шалгалт хийж, 2 ААН-д албан шаардлага хүргүүлж, СБД-ийн 14, ЧД-ийн 18 дугаар хороонд хэрэгжиж буй Сэлбэ 20 минутын дахин төлөвлөлтийн төсөлд Хот байгуулалт, хотын стандартын газарт зөрчил арилгуулах мэдэгдэл хүргүүлсэн. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Гүйцэтгэгч “Морин сувд” ХХК-д зөрчлийн хэрэг нээсэн.<br>➢ Өргөх байгууламжийн чиглэлээр 378 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илрүүлсэн зөрчлийн 99 хувийг арилгуулсан. 28 аж ахуйн нэгжид нийт 75.9 сая төгрөгийн торгууль ногдуулж, 8 өргүүрийг буулгаж ашиглалтаас хассан.<br>➢ Нийслэлийн хэмжээнд бетон зуурмагийн үйлдвэрлэл эрхэлдэг 86 ААН-аас 58 (67%)–д хяналт шалгалт хийж, 32 ААН-д улсын ахлах байцаагчийн зөвлөмж, 10 ААН-д хугацаатай албан шаардлага хүргүүлж, тусгай зөвшөөрөлгүй, тохирлын гэрчилгээгүй 10 ААН-д зөрчлийн хэрэг бүртгэл нээж, 50.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан.<br>➢ Явган замын хавтангийн 7 үйлдвэрт шалгалт хийж, дээж сорьцыг лабораторид шинжлүүлэн зөвлөмж хүргүүлсэн.<br>➢ Арматур худалдаа эрхэлдэг 6 аж ахуйн нэгжид шалгалт хийж, зөрчилтэй 2 ААН-д хэрэг бүртгэл нээж 10.0 сая төгрөгийн торгууль ногдуулан, зөрчил арилгуулах албан даалгавар хүргүүлсэн.<br>➢ Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж буй нийт 49 иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 4 зөвлөмж, 37 албан шаардлага хүргүүлж, 6 аж ахуйн нэгж, байгууллагад 12 сая төгрөгийн торгууль ногдуулсан. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 84 | Арга хэмжээ 3.3.2<br>Дэд бүтцийн салбарын хяналтын чиглэлээр 79 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | - | Объектын тоо | 29 | 79 | Дэд бүтцийн салбарын 4 хяналтын чиглэлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад нийт 194 объектыг хамруулав. Хяналт шалгалтын ажлаас дурдвал:<br>➢ Эрчим хүчний хангамж, уурын болон усан халаалтын зуухны техник ашиглалт, аюулгүй ажиллагааны хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 30 обьектыг хамрууллаа. Сонгинохайрхан, Налайх дүүргийн 10 аж ахуйн нэгжийн 18 уурын болон усан халаалтын зууханд шалгалт хийж, 1 ААН-д 5.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 6 ААН-д албан шаардлага хүргүүлэв. Мөн ХУД-ийн 15-р хороонд дулаан хангамжийн байгууллагуудад, Улаанбаатар дулааны сүлжээ болон УБЦТС ТӨХК-ийн дулаан, цахилгааны хангамжийн ашиглалтын байдалд үзлэг шалгалт хийж хугацаатай албан шаардлагууд хүргүүлэн ажиллав.<br>➢ Зам, тээврийн хөгжлийн яамны удирдамжийн дагуу авто зам, гүүр, байгууламжийн ажлын явц, аюулгүй байдал, зураг төслийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж нийт 5 обьектыг хамруулав.<br>➢ Зам, тээврийн яамны удирдамжийн дагуу “Вьетнам засвар”-ын үйл ажиллагаа явуулдаг 43 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулан хяналт шалгалт хийв. Шалгалтаар нийт 26 нэр төрлийн 198 зөрчил илрүүлж, 5 иргэн, 9 аж ахуйн нэгжид нийт 4.75 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Мөн 86 заалт бүхий 13 | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | албан даалгавар хүргүүлж, холбогдох байгууллагуудад шалгалтын дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан хүргүүллээ.<br>➢ Ахуйн хэрэглээний 220 гр хийн баллоны худалдаа, шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээний аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж нийт 116 обьектыг хамруулав. Томоохон зах, худалдааны төвүүдийн 107 иргэн, ААН-д шалгалт хийж улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. Мөн төлөвлөгөөт бус хяналтаар 9 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт шалгалт хийж хугацаатай албан шаардлага гаргаж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. | |
| **Зорилт 3.4. Салбарын хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 85 | Арга хэмжээ 3.4.1<br>Удирдах байгууллага, албан тушаалтнаас өгөгдсөн цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Удирдах байгууллага, албан тушаалтнаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу дараах хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Үүнд:<br>- Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд Сүхбаатар дүүргийн 8-р хороо Олимпик ресиденсийн гадна явган хүний зам талбайн эвдрэлд хяналт шалгалт хийсэн. Модун Монголиа ХХК-д орчны 50 метр талбайн ашиглалт, үйлчилгээг хариуцаж ажиллах хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд нийтийн | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | эзэмшлийн зам талбайн эвдрэлийг засч сайжруулах талаар мэдэгдэл хүргүүлж, 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс зам талбайн засварын ажлыг эхлүүлсэн бөгөөд гүйцэтгэгчээр “Тэмүүлэн сүрвэй“ ХХК ажиллаж, нийт 42,6 мк.в талбайг шинэчлэн засварлаж байна.<br>- Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай даргын баталсан удирдамжийн хүрээнд Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн 7, 11, 23, 28, 30, 31 хороонд хоёрдогч түүхий эд авах, тос тосолгооны материал худалдаалах,авто засвар, авто угаалга, дугуй засварын газрын нийт 45 байршилд хяналт шалгалт хийж, шаардах хуудас хүргүүлэн 4 байршилд тус дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас мэдэгдэх хуудас хүргүүлсэн.<br>- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/214 дугаартай захирамжаар нийслэлийн нийт 9 дүүрэгт 2025 оны 02 дугаар сарын 18-25-ны өдрүүдэд нийт 770 нийтийн байрны орчин, нөхцөлд хяналт шалгалт зохион байгуулсан. Шалгалтаар нийт 7630 зөрчил илрүүлж, 2334 зөвлөмж, 403 мэдэгдэл, 12 албан шаардлага хүргүүлсэн.<br>- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Б.Сэмжидмаагаас ирүүлсэн гомдлын дагуу Баянгол дүүргийн 19 дүгээр хорооны 58 дугаар байрны зүүн урд явган хүний зам дээр барилга барьж байгаатай холбогдуулан шалгалт хийж, 2025 оны 09 дүгээр сарын | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | 24-ний өдөр албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Ихбаяраас ирүүлсэн гомдлын дагуу Баянгол дүүргийн 14-р хороо, Москва комплексын зоорины давхрыг автомашины зогсоол болгон өөрчлөн тохижуулах ажилд хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн дутагдал арилгах тухай албан шаардлага хүргүүлсэн. | |
| 86 | Арга хэмжээ 3.4.2<br>Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | - | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/<br>Зөрчил арилгалт /хувь/ | - | 100 | Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 2825 албан бичиг, 2521 өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт зохион байгуулж, хуулийн хугацаанд хариуг хүргүүлж, шалгалтаар илэрсэн зөрчлүүдэд улсын байцаагчийн эрх хэмжээний хүрээнд 82 зөвлөмж, 431 албан шаардлага, 116 албан даалгавар, 486 дүгнэлт боловсруулж, холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэн, зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад нийт 503.5 сая төгрөгийн торгууль ногдуулав. | 100% |
| 87 | Арга хэмжээ 3.4.3<br>Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх | - | Албан шаардлагын биелэлт /тоо, хувь/<br>Зөрчил арилгалт /хувь/ | - | 100 | Барилга, дэд бүтцийн салбарын хүрээнд хяналт шалгалтын явцад илэрсэн чиглэлээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр тус газрын улсын (ахлах) байцаагчдын нийт 525 албан шаардлага, 337 албан даалгавар хүргүүлж, зөрчил дутагдлыг 82.2 хувиар арилгуулав. | 100% |
| **Зорилт 3.5. Хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, сурталчлан таниулна. /Газрын дүрмийн-4.5.1/** | | | | | | | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 88 | Арга хэмжээ 3.5.1<br>Барилгын салбарт “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аян”-ыг төлөвлөх, эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны сайд болон Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын 2025 оны 100/А101 дугаартай хамтарсан тушаалаар баталсан “Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа” нэг аяны хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:<br>- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025/01 дугаартай албан даалгаврыг хяналт шалгалтад хамрагдсан зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч болон ашиглагч нийт 903 байгууллагад хүргүүлэв.<br>- Зураг төсөл батлах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага болон барилгын захиалагч, угсралт, зураг төсөл боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нийт 320 иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж хүргүүлэв.<br>- “Аюулгүй барилга–Аюулгүй ажиллагаа” сэдэвт онол-дадлага хосолсон сургалтад 164 аж ахуйн нэгжийн 260 орчим инженер, техникийн ажилтныг хамруулав.<br>- Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 30 орчим аж ахуйн нэгжийн 150 гаруй ажилтан, албан хаагчдад зориулсан сургалтыг Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нартай хамтран зохион байгуулсан.<br>- “Нийслэлийн хэмжээнд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | эрхлэгч нарыг чадавхжуулах" сургалтыг зохион байгуулж, 180 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл хамруулав.<br>- Салбарын улсын байцаагчийн 02/00/04 дугаар удирдамжийн дагуу 97 ААН-д шалгалт хийж, их эрсдэлтэй 6 байгууллагад 35.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, дунд эрсдэлтэй 17 байгууллагад албан шаардлага, бага эрсдэлтэй 74 байгууллагад зөвлөмж хүргүүлэв. Үйл ажиллагаа түр зогсоосон 5 ААН-ийн мэдээллийг Шилэн хяналтын системд оруулсан.<br>- Бетон зуурмагийн үйлдвэрлэл эрхэлдэг 86 байгууллагаас 58-д урьдчилан сэргийлэх шалгалт хийж, 32-д зөвлөмж, 10-д хугацаатай шаардлага хүргүүлж, зөрчилтэй 10 ААН-д 50.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан.<br>- Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/05 дугаартай удирдамжийн дагуу 130 иргэн, аж ахуйн нэгжид шалгалт хийж, 143.4 сая төгрөгийн торгууль ногдуулж, гүйцэтгэлийг хангуулах албан даалгавар хүргүүлэв.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг хангах чиглэлээр орон сууц болон олон нийтийн 450, сургууль цэцэрлэгийн 160, нийт 610 иргэн, аж ахуйн нэгжид шалгалт хийж, зөвлөмж хүргүүлэв.<br>- Барилга угсралтын талбайн түр хашааны стандартыг хэрэгжүүлэх хүрээнд 110 иргэн, ААН-д төлөвлөгөөт бус шалгалт | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хийж, стандартын хэрэгжилтийг хангуулсан.<br>Аяны тайлан болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025/01, 2025/02 дугаартай албан даалгаврын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 01/554 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв. | |
| 89 | Арга хэмжээ 3.5.2<br>Барилгын угсралт, ашиглалт болон дэд бүтцийн салбарт хууль, стандарт, нормыг мөрдүүлэх чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөн туслах, сургалт зохион байгуулах | - | Зохион байгуулсан сургалт | 7 | 11 | Барилгын угсралт, ашиглалт болон дэд бүтцийн салбарт хууль, стандарт, нормын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд нийт 6 чиглэлээр, **17** удаагийн сургалт зохион байгуулж, **3,574** иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг төлөөллийн хамруулав. Үүнд:<br>1) Барилга байгууламжийн ашиглалт, орчны аюулгүй байдлын чиглэлээр 3 сургалт зохион байгуулж, төрийн байгууллага, СӨХ, боловсролын салбарын нийт 1,344 төлөөллийг хамруулсан.<br>2) Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийн чадавхжуулах 2 удаагийн сургалтаар захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудын нийт 330 төлөөлөл оролцсон.<br>3) Даралтат сав, шингэрүүлсэн шатдаг хийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны чиглэлээр 9 удаагийн сургалт зохион байгуулж, мэргэжлийн инженер, техникийн ажилтан, байгууллагын төлөөлөл зэрэг нийт 1,552 хүнийг хамруулсан. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | 4) Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Авлигатай тэмцэх газар зэрэгтэй хамтран “Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоо” сэдэвт хэлэлцүүлгийг 04 сарын 16-ны өдөр зохион байгуулж, 200 гаруй төлөөлөл оролцсон.<br>5) “Цамхагт краны аюулгүй байдлыг хангах аян”-ы хүрээнд өргөх байгууламжийн оператор, инженер техникийн ажилчдад сургалтад 42 аж ахуйн нэгж байгууллагын 68 төлөөллийг хамруулсан.<br>6) “Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажилд гардаг нийтлэг зөрчил, дутагдал” сэдвээр 81 захирал, инженер техникийн ажилчдад сургалт зохион байгуулав. | |
| 90 | Арга хэмжээ 3.5.3<br>Хяналт шалгалтын дүнгийн талаар хяналтын чиглэл бүрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Барилга, дэд бүтэц, орчны аюулгүй байдлын хяналтын чиглэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх, урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 21 удаагийн мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим платформуудаар дамжуулан хүргэлээ. Нийслэлийн хэвлэлийн албанд худалдаа, үйлчилгээний байгууллагын гадна хаягжилт, орчны шаардлагын талаар 2 удаагийн ярилцлага, UBS телевиз, Монголын үндэсний радио телевизээр дамжуулан сургууль, цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдал, стандартын хэрэгжилтийн талаар 2 удаагийн ярилцлага өгсөн. Мөн Монгол ТВ-д шатахуун түгээх | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | станцын галын аюулгүйн зай хэмжээний талаарх сэрэмжлүүлэг, зөвлөмж өгч хүргэсэн. Байгууллагын цахим хуудсанд нийт 9 удаа, мөн сонинд 1 удаа мэдээлэл байршуулж, авто зам, замын байгууламжийн арчлалт, цэвэрлэгээний талаар мэдэгдэл гарган 42 аж ахуйн нэгжид хүргүүлсэн. | |
| **ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Зорилт 4.1. Цахим технологийн тусламжтайгаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангана.** | | | | | | | |
| 91 | Арга хэмжээ 4.1.1<br>Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, төлөвлөгөө гарган хамтран ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгын хүрээнд “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хамтран ажиллах төлөвлөгөө”-г 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Ulaanbaatar.mn, “Улаанбаатар мэдээ”, Нийслэлийн хяналт шалгалтын газар болон Inspection.ub.gov.mn цахим хуудсууд, албан ёсны пэйж хуудсуудаар дамжуулан мэдээллийг түгээн ажиллав. Мөн нийт 13 хэвлэл мэдээллийн байгууллага (UBS TV, Eagle TV, gogo.mn, ikon.mn, dorgio.mn, newswire.mn, 24tsag.mn, tovch.mn, news.mn, tsahiur.mn зэрэг)-аар дамжуулан 170 мэдээ нийтэлж, тэдгээрт 19,079 хүн хандсан байна. Үүнээс 525 хүн мэдээг хуваалцаж, 524 хүн сэтгэгдэл үлдээсэн байна. | 100% |
| 92 | Арга хэмжээ 4.1.2<br>Байгууллагын цахим хуудас https://www.inspection.ub.gov.mn/-ны хэвийн үйл ажиллагааг хангах, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн байгууллагын хэмжээнд байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | нээлттэй мэдээллийг тухай бүр байршуулах, шинэчлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах | | | | | байршуулан ажиллаж байна. Байгууллагын вэбсайтын хэвийн үйл ажиллагааг хангах, шинэчлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах үүднээс дараах хөгжүүлэлтүүдийг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>➢ “Мэдээ, мэдээлэл” хэсэгт 21 удаа мэдээ оруулж, бусад мэдээ мэдээллийг засварлав.<br>➢ “Ил тод байдал” хэсгийн Хүний нөөцийн ил тод байдал, Үйл ажиллагааны ил тод байдал, Төсөв, санхүүгийн ил тод байдал, Бусад мэдээллийн ил тод байдал хэсэг тус бүрээр холбогдох мэдээллийг оруулж, харуулах хэсгийг шинээр хөгжүүлсэн.<br>➢ Хүний нөөцийн ил тод байдал хэсэгт Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ функцийг шинээр хөгжүүлж, албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн тайлан, үнэлгээний хуудас мөн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан, үнэлгээний хуудсыг байршуулсан.<br>➢ Шил ажиллагааны хүрээнд вэб сайтад “Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж” функцийг шинээр хөгжүүлсэн.<br>➢ Үйл ажиллагааны ил тод байдал хэсэгт албан хаагчдын мэдээлэл, албаны цахим шуудангийн хаягийг байршуулж, тогтмол шинэчлэсэн.<br>➢ Бусад мэдээллийн ил тод байдал хэсэгт Ёс зүйн дэд хороотой холбоотой шинэ хуудас хөгжүүлж, мэдээллийг байршуулсан.<br>➢ Байгууллагын цахим хуудас Inspection.ub.gov.mn-ийн Админ | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | удирдлага хэсгийн хөгжүүлэлтийг хийж, 90 хувьд хүргэв. Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах хүрээнд Нийтийн мэдээллийн (shilen.gov.mn) цахим системд мэдээлэл хариуцагч байгууллагууд ил тод, нээлттэй байлгах 87 төрлийн “Шилэн индекс”-ийн 2025 оны 02 дугаар улирлын тайланг 06 дугаар сарын 30-ны өдөр илгээж 76.64 хувь, 2025 оны 03 дугаар улирлын тайланг 09 дүгээр сарын 30-ны өдөр илгээж 99.15 хувиар тус тус үнэлэгдэв. | |
| 93 | Арга хэмжээ 4.1.3 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт болон ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод болгох | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Байгууллагын албан ёсны цахим хуудас www.inspection.ub.gov.mn-д барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуваарийг 7 хоног бүр байршуулж, хөгжүүлэлт хийн ажиллав. | 100% |
| 94 | Арга хэмжээ 4.1.4 Нэг цонхны үйлчилгээгээр иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, ил тод, хүртээмжтэй хүргэх зорилгоор Нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр дамжуулан нийт 490 албан бичиг хүлээн авч, шийдвэрлэн ажилласан байна. | 100% |
| 95 | Арга хэмжээ 4.1.5 Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч дүн шинжилгээ хийн түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах | - | Сэтгэл ханамжийн судалгааны давтамж | 2 | 4 | Байгууллагын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн сэтгэл ханамжийг үнэлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг байгууллагын цахим хуудсаар дамжуулан тогтмол авч байна. Судалгаагаар ирсэн санал, шүүмжлэл, давтамж өндөртэй асуудлуудыг үндэслэн үйлчилгээний хурд, ил тод байдал, цахим | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хүртээмжийг сайжруулж, дотоод зохион байгуулалт болон албан хаагчдын харилцаа, хандлагыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Мөн Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс зохион байгуулсан "Төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа"-нд 2 удаа оролцож, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн санал, хүсэлт, шүүмжлэлийг цуглуулах судалгаа авах ажлыг зохион байгуулсан. | |
| **Төлөвлөгөөнд тусгагдсан 35 зорилт 95 арга хэмжээний дундаж биелэлт:** | | | | | | | **97.6%** |

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАЙГАЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ
(ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН) МЭРГЭЖИЛТЭН Ө.ТҮМЭН-ЭРДЭНЭ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН М.ГАЧМАА

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР**

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 03 Улаанбаатар хот

Хяналт шалгалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нийт 4 бүлэг, 35 зорилт, 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулж Нийслэлийн Засаг даргаар 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр батлуулсан. 2025 оны жилийн эцсийн тайлант хугацаанд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн Захиргаа санхүүгийн хэлтсээс 97.6 хувьтай үнэлэн ирүүлсэн байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт ***"Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх журам"***-ын ***Хоёр. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх*** аргачлалын дагуу газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 35 зорилт, 95 арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт №1

| № | Бүлэг | Арга хэмжээ (тоо) | Үүнээс: | | | Хэрэгжилт (хувь) |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 85%-с дээш | 70-85% | 70 хүртэл | |
| 1 | Бодлогын баримт бичигт тусгагдсан 15 зорилт, арга хэмжээ | 18 | 15 | 1 | 2 | 92,2 |
| 2 | Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 14 зорилт, арга хэмжээ | 57 | 57 | - | - | 98,5 |
| 3 | Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх 5 зорилт, арга хэмжээ | 15 | 15 | - | - | 100 |
| 4 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг | 5 | 5 | - | - | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх 1 зорилт, арга хэмжээ | | | | | |
| Нийт | | 95 | 92 | 1 | 2 | 97,6 |

2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт **97.1%** дүгнэж ирүүлсэн нь журмын 2.5.1 дэх заалтын дагуу **“БҮРЭН ХАНГАЛТТАЙ”** гэж үнэлэгдэж байна.

Нийт 95 арга хэмжээнээс

- ***Бодлогын баримт бичигт тусгагдсан*** 18 арга хэмжээний хэрэгжилт 100%-ийн гүйцэтгэлтэй 14, 90%-ийн гүйцэтгэлтэй 1, 70%-ийн гүйцэтгэлтэй 1, 50,-ийн гүйцэтгэлтэй 2 буюу дундажаар **92,2%-ийн** гүйцэтгэлтэй.
- ***Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх*** зорилт арга хэмжээний нийт 57 арга хэмжээний хэрэгжилт 100%-ийн гүйцэтгэлтэй **49**, 90%-ийн гүйцэтгэлтэй **8**, дундажаар **98,6%-ийн** гүйцэтгэлтэй.
- ***Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх*** зорилт арга хэмжээний нийт 15 арга хэмжээний хэрэгжилт бүгд 100%-ийн гүйцэтгэлтэй.
- ***Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх*** зорилт, арга хэмжээний нийт 5 арга хэмжээний хэрэгжилт бүгд 100%-ийн гүйцэтгэлтэй.

Журмын 2.5.2 дэх заалтын дагуу хэрэгжилт 70-85% гүйцэтгэлтэй **ХАНГАЛТТАЙ** үнэлгээ авсан арга хэмжээ:

Хүснэгт №2

| **№** | **Арга хэмжээ** | **Хэрэгжилтийн хувь** | **Хариуцсан хэлтэс** |
|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ 1.3.1**<br>Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын нэгдсэн цахим системийг хөгжүүлэх | 70 | ЗСХ, БСАБХХ, ДБСХХ |

Журмын 2.5.2 дэх заалтын дагуу хэрэгжилт 70%-иас доош гүйцэтгэлтэй **ХАНГАЛТГҮЙ** үнэлгээ авсан арга хэмжээ:

Хүснэгт №3

| **№** | **Арга хэмжээ** | **Хэрэгжилтийн хувь** | **Хариуцсан хэлтэс** |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ 1.12.1**<br>Барилгын болон автозамын материал, хийц, бүтээц, эзлэхүүний шинж чанарыг тодорхойлох, газрын тос, хийн үзүүлэлтийг хэмжих, сорилт шинжилгээний лаборатори байгуулах бэлтгэл ажлыг хангуулах | 50 | ЗСХ,<br>БСАБХХ,<br>ДБСХХ |
| 2 | **Арга хэмжээ 1.9.1**<br>Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчилд хариуцлага ногдуулах | 50 | ДБСХХ |

**Дүгнэлт:**

Хүснэгт 2-д үзүүлсэн 70%-ийн гүйцэтгэлтэй 1 арга хэмжээ байгаа нь *ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.5.2 "Төлөвлөгөөний хэрэгжилт 70-85 хувьтай* бол **ХАНГАЛТТАЙ** гэж үнэлэх боловч шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, ***зохион байгуулалт хариуцлагыг сайжруулах*** гэсэн заалтад хамрагдаж байна.

Хүснэгт 3-д үзүүлсэн 50%-ийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээ байгаа нь *ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.5.3 "Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хүртэл хувьтай* бол **ХАНГАЛТГҮЙ** гэж үнэлэн, ***удирдлага зохион байгуулалт хангалтгүй,*** *төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон* гэсэн заалтад хамрагдаж байна.

2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 35 зорилт, 95 арга хэмжээний хэрэгжилт 97,6 хувийн гүйцэтгэлтэй буюу **БҮРЭН ХАНГАЛТТАЙ** үнэлэгдсэн.

БОЛОВСРУУЛСАН:
ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ө.ТҮМЭН-ЭРДЭНЭ